



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

СНАГ-2025/001/НА-СТА-ЗГСНТ

2025 он



Тайлан бэлтгэсэн:	АГУУЛГА	
Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч: Я.Самбууням	1. АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ	4
Санхүү,нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг	2. АУДИТ ХИЙСЭН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН	7
	2.1 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	7
	2.2 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН ..	8
	2.3 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	9
	2.4 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	10
Тусгай хяналтын хэлтсийн дарга Б.Лхагвацэнд	3.1 ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ	11
Аудитын менежер: Д.Энхдалай А.Цогбаяр С.Нацагдорж	3.1.1 Аудит хийсэн үндэслэл	11
	3.1.2 Аудитын зорилт, хамарсан хүрээ	11
	3.1.3 Аудитын арга зүй	11
	3.1.4 Материаллаг байдлын түвшин	11
	3.2 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭХЭД БАРИМТАЛСАН АРГАЧЛАЛ, ЗАРЧИМ	11
	3.2.2 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн	12
	3.3 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР ..	12
Ахлах аудитор: А.Даваадорж Ж.Бүжинханд Б.Долгоржав Б.Эрдэнэзул Г.Мөнхчимэг С.Отгонхорлоо Д.Мөнхжин Б.Ариунжаргал П.Батцэцэг	3.3.1 Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	12
	3.3.2 Санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	13
	3.3.3 Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	13
	3.3.4 Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	13
	4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
Аудитор: М.Ганбаатар О.Наранбат М.Лхагвасүрэн Д.Эрдэнэчимэг Г.Оюунтөгөлдөр Д.Номингуя Я.Марал-Эрдэнэ Г.Ганбилэг С.Болортуяа Ж.Бямбацогт Э.Бат-Эрдэнэ	4.1 МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	13
	Төв төрийн сангийн мөнгөн хөрөнгө	14
	Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө	15
	Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө	16
	Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгө	16
	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгө	17
	4.2 БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	18
	4.3 АВЛАГА	19
	Төв төрийн сангийн авлага	19
	Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага	20
	Төсөвт байгууллагын авлага	21
	Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн авлага	21
	Нийгмийн даатгалын сангийн авлага	23
	Эрүүл мэндийн даатгалын сангийн авлага	23
	4.4 УРЬДЧИЛГАА	24
	4.5 БАРАА МАТЕРИАЛ	25
	4.6 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	26
2025 оны 6 дугаар сар	4.7 УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	26
	4.8 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	27
Уг тайланг УАГ-ын Цахим хуудаснаас үзнэ үү: www.audit.mn	4.9 ӨР ТӨЛБӨР	28
	Төв төрийн сангийн өр төлбөр	29
	Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн өр төлбөр	31
	Төсөвт байгууллагын өр төлбөр	32
	Нийгмийн даатгалын сангийн өр төлбөр	33
	Эрүүл мэндийн даатгалын сангийн өр төлбөр	34
Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261663 дугаар утсаар харилцана уу.	4.10 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО	34
	4.11 ЗАСГИЙН ГАЗРЫН БОЛОН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДЫН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ...	35
	Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит	35
	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит	36
ХАЯГ: Үндэсний аудитын газар Засгийн газрын IV байр, Бага тойруу-6, Улаанбаатар-46 Монгол Улс	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайлангийн аудит	36
	Засгийн газрын гадаад зээл, тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн санхүүгийн тайлангийн аудит	40
	Засгийн газрын тусгай сангуудын санхүүгийн тайлангийн аудит	41



4.12 САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗАЛРУУЛГА.....	42
4.13 ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ	43
5. АУДИТЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	44
5.1 АУДИТЫН ДҮГНЭЛТ	44
5.2 АУДИТЫН ЗӨВЛӨМЖ	45

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АЗЗА	Авто зам, засвар арчлалт
АҮЭБС	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд
БОУАӨС	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд
БС	Боловсролын сайд
ГБХНХС	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ГХС	Гадаад харилцааны сайд
ЖДҮХС	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗТС	Зам тээврийн сайд
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
МИАТ	Монголын иргэний агаарын тээвэр
МУЕС	Монгол Улсын Ерөнхий сайд
МУИС	Монгол Улсын Их сургууль
МУШС	Монгол Улсын Шадар сайд
МУШСБЭЗХС	Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд
МУДШ	Монгол Улсын Дээд шүүх
МУСХҮҮХД	Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний үндэсний хорооны дарга
НББ	Нягтлан бодох бүртгэл
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
НДС	Нийгмийн даатгалын сан
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНӨХХК	Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ССАЖЗС	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
СС	Сангийн сайд
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮОМШӨ	Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин
ҮЦК	Үнэт цаасны компани
ХББОСС	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман улс
ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦАУЗБУКД	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссын дарга
ЦХИХХС	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ЭЗХС	Эдийн засаг, хөгжлийн сайд
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭХС	Эрчим хүчний сайд



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ
ТАНАА

2025.06.08 № 1915
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2-т заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал болон үр дүн, мөнгөн гүйлгээний тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг, хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 9,292.1 тэрбум төгрөгийн зөрчил илэрч бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Монголбанкнаас тогтоосон банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаагүй Чингис хаан, Үндэсний хөрөнгө оруулалтын банканд байршиж байгаа байгууллагуудын нийт 256.9 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгөд эрсдэл үүссэн асуудлыг эцэслэн шийдвэрлээгүй;
- Төрөөс иргэдийн боловсрол, хөдөлмөр эрхлэлт, бизнесийг дэмжих зорилгоор засгийн газрын тусгай сангуудаас олгосон зээл болон эргэн төлөгдөх нөхцөлтэй дэмжлэгээс 96.5 тэрбум төгрөг нь чанаргүй зээлийн ангилалд багтсан, 212.4 тэрбум төгрөгийн үлдэгдэл эргэн төлөгдөөгүй, хугацаа хэтэрсэн;

- Төсвийн зарлагын эх үүсвэрийн 5,057.7 тэрбум төгрөгийг төрийн сангийн тайланд өглөгөөр тайлагнаж, санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг бууруулж нэгтгэсэн;
- Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийн эх үүсвэрээс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр дамжуулан зээлдүүлсэн олон жилийн насжилттай, хугацаа хэтэрсэн, эргэн төлөлт хийгдээгүй 977.7 тэрбум төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй, үүнээс 492.4 тэрбум төгрөгийн авлагыг зарим төсвийн ерөнхийлөн захирагчид тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- Капитал банкны эрх хүлээн авагчаас авах Нийгмийн даатгалын сангийн 65.7 тэрбум төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангийн 76.0 тэрбум төгрөг, нийт 141.7 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулах ажил удаашралтай, олон жилийн насжилттай, найдваргүй болох эрсдэлтэй хэвээр байгаа зэрэг нь санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Үндэсний баялгийн сангийн тухай хууль батлагдсантай холбоотойгоор уул уурхайн олборлолт, ашигт малтмал боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн төрийн эзэмшилд ногдох 34 хувийн ногдол ашиг 495.7 тэрбум төгрөгийг хуримтлалын санд төвлөрүүлжээ.

Хуримтлалын санд төвлөрүүлсэн хөрөнгийг иргэн бүрд нэрийн данс нээж хуваарилсан бөгөөд иргэд өөрийн нэрийн дансанд төвлөрсөн хуримтлалыг И-Монгол цахим системийг ашиглан хянах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2024 оны 14 дүгээр тогтоолын дагуу нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс 300.0 тэрбум төгрөгөөр Засгийн газрын дотоод үнэт цаас худалдан авч, тайлант онд 3.4 тэрбум төгрөгийг хүүгийн авлагаар бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд тусад нь дүгнэлт гаргахгүй.

Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар “Тавантолгой түлш” ХХК-ийн төрийн эзэмшлийн хувийг Нийслэлийн өмчид шилжүүлэхээр, хоёрдугаар хавсралтаар хуримтлагдсан өр төлбөрийг шийдвэрлэх арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасан боловч өр төлбөрийн асуудлыг бүрэн шийдвэрлээгүйгээс шалтгаалан Нийслэлийн өмчид шилжүүлээгүй, тогтоолын хэрэгжилт хангалтгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Монгол Улсын зээлжих зэрэглэл 2024 онд нэмэгдэж Фитч зээлжих зэрэглэл тогтоогч агентлаг В+ тогтвортой түвшинд, Эс энд Пи зээлжих зэрэглэл тогтоогч агентлаг В+ зэрэг түвшинд, Мүүдис зээлжих зэрэглэл тогтоогч агентлаг В2 тогтвортой түвшин болгон нэмэгдүүлсэн байна.

Гадаад бондыг хугацаанаас өмнө буцаан худалдан авч төсөвт хэмнэлт бий болгосон, "Номад", "Сенчири-1" бондуудыг хоёрдогч зах зээлээс хямд үнээр, буцаан худалдан авч 3.2 сая ам.долларын хэмнэлт үүсгэсэн нь өрийн зардлыг бууруулах үр дүнтэй арга хэмжээ болсон байна.

Улсын Их Хурлын 2024 оны 10 дугаар тогтоол, Засгийн газрын 2024 оны 45 дугаар тогтоолоор 2012 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд төрсөн болон харьяат болсон Монгол Улсын иргэн бүрд "Эрдэнэс тавантолгой" ХК-ийн 1,072 ширхэг энгийн хувьцааг эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлын хэсгийг хамраагүй болно.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Сангийн яам Монгол Улсын Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С.МАГНАЙСҮРЭН

**2. АУДИТ ХИЙСЭН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН****2.1 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

		/мянган төгрөгөөр/	
Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	39,419,277,113.1	49,372,928,360.7
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	12,090,945,132.6	14,545,799,856.8
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	418,881,028.8	1,842,307,057.7
33	АВЛАГА	6,445,231,920.4	6,811,689,606.3
34	УРЬДЧИЛГАА	5,137,620,748.6	5,891,559,868.9
35	БАРАА МАТЕРИАЛ	3,651,951,120.1	4,262,438,394.5
36	НӨӨЦИЙН БАРАА	210,051,565.0	262,209,470.4
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	11,464,595,597.5	15,756,924,106.1
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	67,291,238,825.4	72,865,145,012.5
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	11,769,862,213.5	13,291,996,604.4
37100	Урт хугацаат хадгаламж	60,011,802.6	57,967,999.0
37200	Үнэт цаас	3,270,019,664.8	2,659,976,425.7
37300	Урт хугацаат зээл	8,439,830,746.1	10,574,052,179.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	55,521,376,611.9	59,573,148,408.1
39100	Газар	45,966,490.4	88,356,552.1
39200	Биет хөрөнгө	29,965,023,636.4	34,670,430,787.6
39300	Биет бус хөрөнгө	19,086,188,106.6	19,557,894,835.6
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	6,424,198,378.5	5,256,466,232.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	106,710,515,938.5	122,238,073,373.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	55,194,185,569.9	57,724,001,648.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	12,747,684,009.8	13,317,636,121.3
41100	Богино хугацаат үнэт цаас	512,800,167.0	10,044,464.2
41200	Богино хугацаат зээлийн өглөг	3,199,246,995.7	3,653,406,208.7
41300	Өглөг	5,790,559,799.8	6,639,710,951.9
41400	Урьдчилж орсон орлого	3,245,077,047.3	3,014,474,496.5
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	42,446,501,560.1	44,406,365,527.4
42100	Урт хугацаат үнэт цаас	13,595,979,135.8	15,560,012,015.6
42200	Урт хугацаат зээл	28,850,522,424.4	28,846,353,511.8
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	51,516,330,368.6	64,514,071,724.5
51	Засгийн газрын хувь оролцоо	51,500,867,171.7	64,498,608,527.6
51100	Засгийн газрын оруулсан капитал	8,029,230,876.5	7,867,789,183.3
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	7,032,475,637.8	7,548,982,568.4
51102	Өмч /хувийн/ /ТӨҮГ/	490.0	15,495,693.0
51103	Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/	11,255,546,353.9	11,256,095,009.3
51105	Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	18,816,486.3	18,396,486.3
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	9,608,439,840.2	10,063,086,010.1
51200	Хуримтлагдсан үр дүн	7,962,257,539.4	20,063,740,822.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,444,269,487.7	7,510,105,807.9
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	149,867,039.0	154,699,287.1
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	(36,579.0)	217,659.9
52	Хяналтын бус хувь оролцоо	15,463,196.9	15,463,196.9
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	106,710,515,938.5	122,238,073,373.2



2.2 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	42,806,640,395.7	56,004,733,843.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО	22,517,720,993.2	28,609,895,207.6
110	Орлогын албан татвар	5,928,733,767.2	9,114,948,948.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	1,885,081,947.9	2,630,433,367.1
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(64,524,799.5)	(78,897,501.5)
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	8,415.4	10,148.6
1103	ААН-ын орлогын албан татвар	4,108,168,203.4	6,563,402,934.0
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	4,184,392,112.1	4,774,274,408.3
113	Хөрөнгийн албан татвар	394,899,780.5	459,508,615.1
114	Нэмэгдсэн өртгийн албан татвар	4,791,429,999.5	5,843,603,928.3
115	Онцгой албан татвар	790,106,602.8	1,098,207,320.2
116	Тусгай зориулалтын орлого	21,623,528.1	26,427,609.4
117	Гадаад үйл ажиллагааны орлого	1,470,679,247.5	1,792,591,942.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж	4,935,855,955.5	5,500,332,435.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20,107,466,980.4	26,801,347,073.5
120	Нийтлэг татварын бус орлого	19,712,069,037.2	26,054,350,084.7
121	Хөрөнгийн орлого	9,874,524.2	172,380,867.7
122	Тусламжийн орлого	378,730,223.1	555,765,924.7
124	Зээлийн орлого	6,793,195.8	18,850,196.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	181,452,422.1	593,491,562.6
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	28,870,897,862.2	35,164,266,044.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	28,828,467,769.3	35,088,288,689.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	19,267,915,399.5	23,707,900,940.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,981,120,212.1	7,077,250,149.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	533,863,660.6	744,182,818.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	511,367,081.6	592,485,853.3
2104	Хангамж, бараа материалын зардал	756,430,479.9	967,852,839.2
2105	Нормативт зардал	709,817,910.7	807,223,893.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	175,171,069.6	203,360,256.6
2107	Томилолт, зочны зардал	114,799,766.5	148,940,012.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,450,228,438.0	9,239,320,862.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,035,116,780.6	3,927,284,254.9
211	ХҮҮ	1,629,919,018.9	1,763,746,352.2
212	ТАТААС	657,447,140.7	827,351,602.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,273,186,210.2	8,789,289,794.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	42,430,092.8	75,977,354.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	13,935,742,533.6	20,840,467,799.4
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	5,563,099,951.1	6,833,821,515.8
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	8,339,672,193.6	10,337,583,356.9
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	11,159,170,291.0	17,336,705,958.3

**2.3 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	39,784,824,052.3	-	39,784,824,052.3
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(636,723,467.2)	-	(636,723,467.2)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	39,148,100,585.1	-	39,148,100,585.1
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	2,233,304.0	-	2,233,304.0
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	302,018,042.4	-	302,018,042.4
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	(972,801.4)	-	(972,801.4)
Өмчид гарсан өөрчлөлт	1,374,503,463.6	-	1,374,503,463.6
Зарласан ногдол ашиг	(477,356,071.3)	-	(477,356,071.3)
Тайлант үеийн үр дүн	11,167,803,846.1	-	11,167,803,846.1
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	51,516,330,368.5	-	51,516,330,368.5
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	834,319,916.5	-	834,319,916.5
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	52,350,650,285.0	-	52,350,650,285.0
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	13,536,984.3	-	13,536,984.3
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	71,666,831.3	-	71,666,831.3
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	(2,151,144.2)	-	(2,151,144.2)
Өмчид гарсан өөрчлөлт	(98,013,329.6)	-	(98,013,329.6)
Зарласан ногдол ашиг	(5,158,323,860.6)	-	(5,158,323,860.6)
Тайлант үеийн үр дүн	17,336,705,958.3	-	17,336,705,958.3
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	64,514,071,724.5	-	64,514,071,724.5



2.4 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	54,752,207,804.5	80,088,231,655.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	22,813,069,711.7	28,805,773,488.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	1,888,562,750.7	2,629,996,078.5
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(64,500,676.2)	(78,897,501.5)
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	8,415.40	10,148.6
1103	ААН-ын орлогын албан татвар	4,108,168,203.4	6,563,402,934.0
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	4,149,150,964.1	5,149,605,490.0
113	Хөрөнгийн албан татвар	394,816,367.3	459,452,695.5
114	Нэмэгдсэн өртгийн албан татвар	4,779,728,129.4	5,863,600,982.3
115	Онцгой албан татвар	790,106,602.8	1,098,932,420.3
116	Тусгай зориулалтын орлого	21,623,528.1	26,427,609.4
117	Гадаад үйл ажиллагааны орлого	1,465,340,213.9	1,792,341,760.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	5,280,065,212.8	5,300,900,871.0
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	4,959,653,364.0	4,909,296,718.4
1181	Газрын төлбөр	194,609,052.6	239,016,402.1
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	110,341,807.3	121,881,019.7
1183	Бусад татвар	15,460,988.9	30,706,730.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	31,276,817,245.8	50,630,134,322.6
120	Нийтлэг татварын бус орлого	31,181,047,346.5	50,528,101,382.4
121	Хөрөнгийн орлого	9,874,524.2	6,832,631.8
122	Тусламжийн орлого	85,093,581.1	95,200,308.4
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	801,794.0	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	662,320,847.0	652,323,844.9
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	39,949,103,843.5	67,162,596,187.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	39,949,103,843.4	67,162,596,187.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	30,054,589,657.9	55,226,188,703.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,454,858,139.7	8,910,200,894.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	964,978,245.8	1,270,983,118.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,024,231,504.4	1,152,008,600.6
2104	Хангамж, бараа материалын зардал	5,805,252,971.2	6,170,585,253.2
2105	Нормативт зардал	564,445,092.2	736,087,186.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	203,123,325.5	263,416,937.4
2107	Томилолт, зочны зардал	115,653,437.4	145,615,220.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,769,964,825.4	34,390,150,600.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,152,082,116.3	2,187,140,891.2
211	ХҮҮ	1,670,643,632.8	1,800,008,843.4
212	ТАТААС	470,663,109.5	686,109,231.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,753,207,443.2	9,450,289,410.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	14,803,103,961.1	12,925,635,468.1
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	10,962,821,723.1	18,332,010,314.5
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	17,148,319,196.2	27,263,741,028.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,148,319,196.2	27,263,741,028.8
2200	Дотоод эх үүсвэрээр	17,145,069,525.2	27,261,227,951.7
2260	Гадаад эх үүсвэрээр	3,249,671.0	2,513,077.1
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(6,185,497,473.1)	(8,931,730,714.3)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(3,163,331,925.1)	(1,539,050,029.6)
14	Бусад эх үүсвэр	5,311,296,700.7	7,155,354,921.4
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	344,088,900.9	325,952,235.1
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	3,680,380,794.2	2,284,047,471.8
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	4,450,158,930.7	6,084,405,244.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	5,454,274,562.9	2,454,854,724.2
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,636,670,569.7	12,090,945,132.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,090,945,132.6	14,545,799,856.8



3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1 ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

3.1.1 Аудит хийсэн үндэслэл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2-т заасныг тус тус үндэслэн Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

3.1.2 Аудитын зорилт, хамарсан хүрээ

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг УСНББОУС, СТОУС, санхүүгийн тайлагналын үзэл баримтлалд нийцүүлэн үнэн зөв илэрхийлсэн эсэхэд дүгнэлт гаргаж, үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгуудад Аудитын олон улсын стандарт, Төрийн аудит MNS 6817-4:2020 Санхүүгийн аудитын тулгуур зарчимд заасны дагуу аудитын горим, сорилыг төлөвлөж, хэрэгжүүлсэн.

Төрийн аудитын байгууллага нь Монгол Улсын Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, дүгнэлт гаргахын өмнө Төрийн аудитын тухай болон Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн захирагчид, төсөл, хөтөлбөр, сан, төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2024 оны санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан болно.

3.1.3 Аудитын арга зүй

Монгол Улсын Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмыг үнэлж, санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүдийг үндсэн шалгуур болгон хяналтын сорил, шинжилгээний горим гүйцэтгэж, түүврээр ажил гүйлгээ, тооцооллыг давтан шалгаж үнэлгээ өгөв.

Төрийн аудитын байгууллагаас 2024-2025 онд гүйцэтгэх аудитад баримтлах ерөнхий чиглэл, мөн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж болон бусад эрх зүйн актын хэрэгжилт, тэдгээрийн нийцэл зэрэг асуудлуудыг тусгайлан авч үзэж, үр дүнг тайланд тусгасан.

3.1.4 Материаллаг байдлын түвшин

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн байгууллага, төрийн сан, төсөл, хөтөлбөр, төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг нэгтгэсэн тул материаллаг байдлын түвшнийг төлөвлөлтийн үе шатанд Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 37,210.6 тэрбум төгрөгийн 1.0 хувь буюу 372.1 тэрбум төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.2 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭХЭД БАРИМТАЛСАН АРГАЧЛАЛ, ЗАРЧИМ

Сангийн яам Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1 дэх заалтын дагуу Монгол Улсын Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэн, хуулийн хугацаанд Үндэсний аудитын газарт ирүүлсэн.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу дараах байдлаар бэлтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн тайланд ТЕЗ хоорондын тооцоогоор баталгаажуулсан өр төлбөр, авлага, ажил гүйлгээний давхардсан нийт 10,635.9 тэрбум төгрөгийг санхүүгийн байдлын



тайланд, 27,440.0 тэрбум төгрөгийг санхүүгийн үр дүнгийн тайланд, 28,164.1 тэрбум төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд тус тус цэвэрлэх бичилт хийсэн;

- Төсвийн байгууллага, төсөл сан, төрийн сан, төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээд гэсэн төрлөөр ангилан тайлагнасан.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Төв төрийн сан, НДС, ЭМДС, улсын болон орон нутгийн 61 ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тэдгээрийн харьяа 5,559 төсөвт байгууллага, үүнээс 2,560 гүйцэтгэл, үр дүнгээр санхүүждэг байгууллага, 638 төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээд, 370 төрийн сан, 349 төсөл, сан, нийт 6,916 санхүүгийн тайланг нэгтгэсэн байна.

3.2.1 Тайланг илэрхийлсэн мөнгөн нэгж

Монгол Улсын Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлжээ.

3.2.2 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн яамны “Э-тайлан” программаар нэгтгэн гаргасан бөгөөд дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна.

А. Үндсэн тайлан	Б. Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан	В. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тайлбар, тодруулга
Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	НББ-ийн бодлого, зарчим 3-21 дүгээр тодруулгууд
Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	1а, 1б, 2а, 2б тодруулга
Засгийн газрын нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	Байгууллагын төрлөөрх нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	
Засгийн газрын нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	Байгууллагын төрлөөрх нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	

3.3 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР

3.3.1 Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт хөрөнгө болон өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн 122,238.1 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 14.6 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт №1. Нийт хөрөнгө ба нийт өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч /сая төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Эргэлтийн хөрөнгийн дүн	39,419,277.1	49,372,928.3	9,953,651.2	40.4
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	67,291,238.8	72,865,145.0	5,573,906.2	59.6
Нийт хөрөнгийн дүн	106,710,515.9	122,238,073.3	15,527,557.4	100.0
Нийт өр төлбөр	55,194,185.6	57,724,001.6	2,529,816.0	47.2
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	51,516,330.3	64,514,071.7	12,997,741.4	52.8
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	106,710,515.9	122,238,073.3	15,527,557.4	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт хөрөнгө өмнөх оноос 15,527.6 тэрбум төгрөгөөр өсөхөд Ирээдүйн өв сан 2,674.5 тэрбум төгрөг, Нийслэлийн ЗДТГ 1,959.8 тэрбум төгрөг, Монгол Улсын Хөгжлийн банк ХХК 1,833.4 тэрбум төгрөг, Эрдэнэс Тавантолгой ХК 1,376.7 тэрбум төгрөг, Төрийн банк ХК 855.5 тэрбум төгрөг, Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК 573.7 тэрбум төгрөг, Хуримтлалын сан 500.5 тэрбум төгрөг, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ 436.4 тэрбум төгрөг, ХББОСЯ-ны хөрөнгө оруулалт, их засвар 405.1 тэрбум төгрөг, Монголын мянганы сорилтын сан 360.2 тэрбум төгрөг, МИАТ ТӨХК 333.2 тэрбум төгрөг, Боловсролын ерөнхий газрын хөрөнгө оруулалт 331.2 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.



3.3.2 Санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны нийт үр дүн 17,336.7 тэрбум төгрөгийн эерэг үзүүлэлттэй гарсан байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээд нийт 8,465.9 тэрбум төгрөгийн ашигтай, төсөл, сангууд 3,228.9 тэрбум төгрөг, төрийн сан 22,504.5 тэрбум төгрөгийн эерэг /орлого нь зардлаасаа их/ үр дүнтэй;
- Төсөвт байгууллагууд нийт 16,862.6 тэрбум төгрөгийн сөрөг /орлого нь зардлаасаа бага/ үр дүнтэй гарсан байна.

3.3.3 Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлангаар Засгийн газрын хувь оролцоо 12,997.7 тэрбум төгрөгөөр, тайлант үеийн үр дүн 6,177.5 тэрбум төгрөгөөр өмнөх оноос тус тус өссөн байна.

3.3.4 Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайланд мөнгөн орлого 105,575.6 тэрбум төгрөг, зарлага 103,120.7 тэрбум төгрөг болж, цэвэр мөнгөн гүйлгээ 2,454.8 тэрбум төгрөгийн эерэг үзүүлэлттэй илэрхийлэгдэж, оны эцэст 14,545.8 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

4.1 МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 14,545.8 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 2,454.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Мөнгөн хөрөнгө дансны ангилал, байгууллагын төрлөөр

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	65,932.9	47,079.2	(18,853.7)	0.3
Банканд байгаа бэлэн мөнгө	11,644,830.4	12,127,963.0	483,132.6	83.4
Замд яваа мөнгөн хөрөнгө	175,036.0	363,218.3	188,182.3	2.5
Хадгаламж	205,145.8	2,007,539.4	1,802,393.6	13.8
Дүн	12,090,945.1	14,545,799.9	2,454,854.8	100.0
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>				
ТӨҮГ болон ОНӨҮГ	6,524,203.3	5,290,523.5	(1,233,679.8)	36.4
Төрийн сан	2,034,989.4	2,982,272.0	947,282.6	20.5
Төсөвт байгууллага	753,143.2	747,339.8	(5,803.4)	5.1
Төсөл/ сан	2,778,609.2	5,525,664.6	2,747,055.4	38.0
Дүн	12,090,945.1	14,545,799.9	2,454,854.8	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2,454.8 тэрбум төгрөгөөр өсөхөд төрийн сангийн 947.3 тэрбум төгрөгөөр, төсөл сангийн 2,747.0 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж, төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 1,233.7 тэрбум төгрөгөөр, төсөвт байгууллагын 5.8 тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.

Касст байгаа мөнгөн хөрөнгийн 46.8 тэрбум төгрөг буюу 99.5 хувь нь төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн, 0.2 тэрбум төгрөг буюу 0.5 хувь нь төсөвт байгууллагын, 0.1 тэрбум төгрөг төсөл сангийн үлдэгдэл тус тус эзэлж байна.

Банканд байгаа мөнгөний хөрөнгийн 12,127.9 тэрбум төгрөгийн үлдэгдэлд 6,521.6 тэрбум төгрөг нь гадаад валют байна. Үүнээс 1,546.7 тэрбум төгрөг нь төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн, 807.5 тэрбум төгрөг нь төрийн сангийн, 4,114.4 тэрбум төгрөг нь төсөл сангийн, 53.0 тэрбум төгрөг нь төсөвт байгууллагын гадаад валютын үлдэгдэл байна.



Хадгаламж дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2,007.5 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 1,802.4 тэрбум төгрөгөөр буюу 9.7 дахин өссөн байна.

Хүснэгт №3. Хадгаламж дахь мөнгөн хөрөнгө

/сая төгрөгөөр/

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Зээлийн батлан даалтын сан	131,076.3	-	(131,076.3)	-
Монгол Улсын их сургууль	19,023.7	12,734.1	(6,289.6)	0.6
Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль	5,550.0	3,722.3	(1,827.7)	0.2
Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	10,599.0	17,000.0	6,401.0	0.8
Монгол Улсын Боловсролын их сургууль	17,553.1	15,000.0	(2,553.1)	0.8
Монголын цахилгаан холбоо ХК	1,500.0	-	(1,500.0)	-
Шинжлэх ухаан, технологийн их сургууль	7,781.6	11,575.5	3,793.9	0.6
Хөдөө аж ахуйн хөдөөгийн хөгжил нэгж	1,472.4	1,360.0	(112.4)	0.1
Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨҮГ	2,000.0	2,250.0	250.0	0.1
Гүний ус ХХК	56.7	83.6	26.9	-
Засгийн газрын байруудын ашиглалтын нэгдсэн захиргаа ТӨААТҮГ	1,202.2	2,019.4	817.2	0.1
Удирдлагын академи	7,330.8	7,508.6	177.8	0.4
Монгол Улсын Хөгжлийн банк ХХК	-	263,152.5	263,152.5	13.1
Нийслэлийн ЗДТГ	-	1,671,133.4	1,671,133.4	83.2
Дүн	205,145.8	2,007,539.4	1,802,393.6	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хадгаламж дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл тайлант онд 1,802.4 тэрбум төгрөгөөр өсөхөд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ 6.4 тэрбум төгрөг, Засгийн газрын байруудын ашиглалтын нэгдсэн захиргаа ТӨААТҮГ 0.8 тэрбум төгрөг, Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨҮГ 0.3 тэрбум төгрөг, Удирдлагын академи 0.2 тэрбум төгрөг, Нийслэлийн ЗДТГ 1,671.1 тэрбум төгрөг, Монгол Улсын Хөгжлийн банк ХХК 263.2 тэрбум төгрөгийн хадгаламжийг шинээр нээсэн нь голлон шалтгаалжээ.

Зээлийн батлан даалтын сангийн хадгаламжийн дансанд тайлагнасан 131.1 тэрбум төгрөгийн эхний үлдэгдлийг банканд байгаа бэлэн мөнгөн хөрөнгө ангилалд шилжүүлэн бүртгэсэн байна.

Төв төрийн сангийн мөнгөн хөрөнгө

Төв төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 909.7 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 863.6 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4. Төв төрийн сангийн мөнгөн хөрөнгө

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт(-)	Дүнд эзлэх хувь
Банканд байгаа бэлэн мөнгө	1,664,413.3	866,224.0	(798,189.3)	95.2
Төгрөг	79,697.7	58,712.3	(20,985.4)	-
Төрийн сан	63,316.8	42,339.2	(20,977.6)	-
Монгол банк	8,857.0	8,857.0	-	-
Арилжааны банк	7,523.9	7,516.1	(7.8)	-
Гадаад валют	1,584,715.6	807,511.7	(777,203.9)	-
Монгол банк	1,584,715.6	801,962.5	(782,753.1)	-
Арилжааны банк	-	5,549.2	5,549.2	-
Замд яваа мөнгөн хөрөнгө	108,926.3	43,486.8	(65,439.5)	4.8
Дүн	1,773,339.6	909,710.8	(863,628.8)	100.0

Эх сурвалж: Төв төрийн сангийн 2024 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгийн нийт үлдэгдлийн 866.2 тэрбум төгрөг буюу 95.2 хувийг банканд байгаа бэлэн мөнгө, 43.5 тэрбум төгрөг буюу 4.8 хувийг замд яваа мөнгөн хөрөнгө тус тус эзэлж байна.

Төв төрийн сангийн мөнгөн хөрөнгөд тайлант онд үйл ажиллагааны орлогоос 19,637.2 тэрбум төгрөг, зээлийн эргэн төлөлт, бусад эх үүсвэрээс 5,456.8 тэрбум төгрөг, гадаад валютын ханшийн зөрүүгийн олз 1,651.1 тэрбум төгрөгийг тус тус бүрдүүлж, өмнөх оны зарцуулагдаагүй



үлдэгдэл 1,773.3 тэрбум төгрөг, нийт 28,518.4 тэрбум төгрөгийн эх үүсвэрээс урсгал зардалд 16,130.9 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 3,093.5 тэрбум төгрөг, эргэж төлөгдөх зээлд 4,458.7 тэрбум төгрөг, гадаад зээлийн үндсэн төлбөрт 2,269.3 тэрбум төгрөг, ханшийн зөрүүнд 1,656.3 тэрбум төгрөг, нийт 27,608.7 тэрбум төгрөгийг зарцуулж, 909.7 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- ЭМЯ-ны гадаад валютын хөрвүүлгийн дансанд эзэн холбогдогч нь тодорхойгүй 10,079.16 ам.доллар буюу 0.03 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй;
- Төсвийн зарлагын эх үүсвэрийн 5,057.7 тэрбум төгрөгийг төрийн сангийн тайланд өглөгөөр тайлагнаж, санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг бууруулж нэгтгэсэн;
- Монгол банкаас тогтоосон банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаагүй Чингис хаан банканд байршиж байгаа 200.8 тэрбум төгрөг, Үндэсний хөрөнгө оруулалтын банканд байршиж байгаа 56.1 тэрбум төгрөг, нийт 256.9 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгөд эрсдэл үүссэн;
- Засгийн газрын 2019 оны 430, 2020 оны 253, 2021 оны 397, 2022 оны 495, 2023 оны 456, 2024 оны 249 дүгээр тогтоолуудыг үндэслэн нийт 1,787.6 тэрбум төгрөгийн тайлант онуудад хэрэгжээгүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг ТЕЗ-дын барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлснээс 2025 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар 21 ТЕЗ-ийн 626 төсөл, арга хэмжээний 726.1 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй.
- Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан 726.1 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээний үлдэгдлээс тайлант онд Засгийн газрын 2024 оны 249 дүгээр тогтоолын 1.6-д заасны дагуу нийт 102.5 тэрбум төгрөгийн 79 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч нь шалгараагүй байхад санхүүжилтийг байршуулсан; /20 минутын хот үндэсний хорооны 50.0 тэрбум төгрөг, Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТУГ-ын 51.4 тэрбум төгрөг, Ховд аймгийн ЗДТГ-ын 1.1 тэрбум төгрөг/;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн чөлөөлөх хугацааг Засгийн газрын 2022 оны 414, 2023 оны 353, 2023 оны 456 дугаар тогтоол, 2024 оны 25 дугаар тэмдэглэлээр тус тус сунгаж, 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөр дууссан боловч ТЕЗ-дын 193 төсөл, арга хэмжээний 105.7 тэрбум төгрөгийн үлдэгдэл санхүүжилт бүрэн чөлөөлөгдөөгүй;

Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,430.8 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 182.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5. НДС-ийн мөнгөн хөрөнгө

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Банканд байгаа бэлэн мөнгө	1,247,781.3	1,430,750.8	182,969.5	100.0
Төрийн сангийн харилцах	112,922.4	114,746.8	1,824.4	8.0
Арилжааны банкны харилцах	1,134,851.9	1,100,696.9	(34,155.0)	76.9
Бусад төсөл, нөөцийн харилцах	5.4	215,307.1	215,301.7	15.0
Нэмэлт санхүүжилтийн харилцах	1.6	-	(1.6)	-
Замд яваа мөнгөн хөрөнгө	575.0	-	(575.0)	-
Дүн	1,248,356.3	1,430,750.8	182,394.5	100.0
<i>Үүнээс, сангийн төрлөөр</i>				
Тэтгэврийн даатгалын сангийн харилцах	452,928.7	361,101.4	(91,827.3)	25.2
Тэтгэмжийн даатгалын сангийн харилцах	202,169.6	327,731.3	125,561.7	22.9
ҮОМШӨ-ний даатгалын сангийн харилцах	577,784.4	484,079.7	(93,704.7)	33.8
Ажилгүйдлийн даатгалын сангийн харилцах	5,168.7	4,167.4	(1,001.3)	0.3
Эрүүл мэндийн даатгалын сангийн харилцах	175.4	8,116.4	7,941.0	0.6
Төвлөрсөн харилцах	9,547.4	30,247.5	20,700.1	2.1
Нөөц сангийн харилцах		215,307.1	215,307.1	15.1
Үйл ажиллагааны харилцах	7.1	-	(7.1)	-
Замд яваа мөнгө	575.0	-	(575.0)	-
Дүн	1,248,356.3	1,430,750.8	182,394.5	100.0

Эх сурвалж: НДС-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан



Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 182.4 тэрбум төгрөгөөр өссөн нь Нийгмийн даатгалын ерөнхий хуульд тэтгэврийн хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих зорилгоор даатгуулагчийн нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогыг байршуулж тэтгэврийн нөөц сантай байхаар заасны дагуу ХААН, Худалдаа хөгжил, Голомт, Төрийн банкин дахь тэтгэврийн нөөц сангийн харилцах дансанд 215.3 тэрбум төгрөгийг байршуулсан, тэтгэмжийн даатгалын сангийн харилцах 125.6 тэрбум төгрөг, төвлөрсөн харилцах 20.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнээс тус тус шалтгаалжээ.

ҮОМШӨ-ний даатгалын сангийн харилцах 93.7 тэрбум төгрөг, тэтгэврийн даатгалын сангийн харилцах 91.8 тэрбум төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангийн харилцах 1.0 тэрбум төгрөгөөр тус тус буурчээ.

Аудитын илрүүлэлт:

- Чингисхаан банк дахь Нийгмийн даатгалын төв сангийн мөнгөн хөрөнгийн 94.9 тэрбум төгрөгийн үлдэгдлээс тайлант онд 1.5 тэрбум төгрөгийг барагдуулсан боловч 93.4 тэрбум төгрөг нь банкнаас гаргах боломжгүй үлдэгдэлтэй хэвээр байна. Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 181 /ШШ2020/02421 дүгээр шийдвэр бүрэн хэрэгжээгүй, Монголбанкнаас Чингисхаан банкиг татан буулгах шийдвэр гараагүй тул санхүүгийн тайланд авлагаар бүртгэх эрх зүйн орчин бүрдээгүй.

Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 156.2 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 4.8 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №6. ЭМДС-ийн мөнгөн хөрөнгө

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төрийн сангийн харилцах	66,384.9	101,141.7	34,756.8	64.7
Арилжааны банкин дахь харилцах	94,672.1	54,729.8	(39,942.3)	35.1
Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	375.0	375.0	0.2
Дүн	161,057.0	156,246.5	(4,810.5)	100.0

Эх сурвалж: ЭМДС-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

ЭМДС-ийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 4.8 тэрбум төгрөгөөр буурахад төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл 34.7 тэрбум төгрөгөөр, нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл 0.4 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж, арилжааны банкин дахь үлдэгдэл 39.9 тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 54.7 тэрбум төгрөг нь арилжааны банк дахь харилцахад, 101.5 тэрбум төгрөг нь төрийн сангийн мөнгөн хөрөнгийн харилцах дансанд тус тус байршиж байна.

Аудитын илрүүлэлт:

- Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2020 оны 181 /ШШ2020/02421 дүгээр шийдвэрээр Чингисхаан банк дахь ЭМДС-ийн харилцах дансны 27.9 тэрбум төгрөгийн үлдэгдлийг тус банкаар төлүүлэхээр шийдвэрлэснээс тайлант онд 0.3 тэрбум төгрөгийг төлүүлсэн, Шүүхийн шийдвэрээс хойш 3.0 тэрбум төгрөгийн хүү нэмэгдэж, тайлант оны жилийн эцсийн байдлаар 30.6 тэрбум төгрөгийн харилцах дансны үлдэгдэл эрсдэлтэй.

Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 9,476.7 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 1,825.0 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7. Улсын ТЕЗ-ийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	65,317.8	46,706.9	(18,610.9)	0.5
Банканд байгаа бэлэн мөнгө	7,361,155.5	9,092,134.3	1,730,978.8	95.9



Замд яваа мөнгөн хөрөнгө	20,072.0	1,486.7	(18,585.3)	0.1
Хадгаламж	205,089.1	336,322.4	131,233.3	3.5
Дүн	7,651,634.4	9,476,650.3	1,825,015.9	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Улсын ТЕЗ-дын мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 9,092.2 тэрбум төгрөг буюу 95.9 хувь нь харилцах данс дахь мөнгөн хөрөнгө, 336.3 тэрбум төгрөг буюу 3.5 хувь нь хадгаламж, 0.5 хувь буюу 46.7 тэрбум төгрөг нь кассат байгаа бэлэн мөнгө, 1.5 тэрбум төгрөг буюу 0.1 хувийг замд яваа мөнгөн хөрөнгө эзэлж байна.

Улсын ТЕЗ-дын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1,825.0 тэрбум төгрөгөөр өсөхөд төсөвт байгууллагын мөнгөн хөрөнгө 61.8 тэрбум төгрөгөөр, төсөл сангийн мөнгөн хөрөнгө 2,679.1 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Тухайлбал:

- Төсөл сангийн мөнгөн хөрөнгийн хувьд Ирээдүйн өв сангийн үлдэгдэл 2,674.5 тэрбум төгрөгөөр, НДС-ийн үлдэгдэл 182.4 тэрбум төгрөгөөр, Зээлийн батлан даалтын сан 113.6 тэрбум төгрөгөөр, Улаанбаатар хотын төлбөрийн чадварт нийцсэн орон сууц ба хотын дахин төлөвлөлтийн төслийн үлдэгдэл 17.8 тэрбум төгрөгөөр, Ухаалаг засаг төсөл II төслийн үлдэгдэл 12.7 тэрбум төгрөгөөр, Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төслийн үлдэгдэл 10.3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн;
- Төсөвт байгууллагын мөнгөн хөрөнгийн хувьд Шүүх шинжилгээний ерөнхий газрын шийдвэр гүйцэтгэх төлбөрийн үлдэгдэл 113.5 тэрбум төгрөг, Мал эмнэлгийн ерөнхий газрын үлдэгдэл 11.5 тэрбум төгрөг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн үлдэгдэл 10.5 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн;

Аудитын илрүүлэлт:

- Батлагдсан төсвийг зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулсан нийт 33.8 тэрбум төгрөг; /ГХС 8.0 тэрбум төгрөг, ХХААХҮС 6.4 тэрбум төгрөг, АҮЭБС 6.0 тэрбум төгрөг, МУШС 2.8 тэрбум төгрөг, БС 2.8 тэрбум төгрөг, ЗТС 2.4 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 5.4 тэрбум төгрөг/
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон гэрээний заалтыг зөрчсөн, биелэлт хангалтгүй, гэрээ байгуулаагүй байхад зардал гаргасан зэрэг нийт 161.6 тэрбум төгрөг; /СС 73.6 тэрбум төгрөг, МУШС 33.8 тэрбум төгрөг, БС 31.3 тэрбум төгрөг, ГБХНХС 16.5 тэрбум төгрөг, ЦХИХХС 2.6 тэрбум төгрөг, МУЕС 1.1 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 2.7 тэрбум төгрөг/
- Монгол банкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаагүй банканд 96.1 тэрбум төгрөгийг байршуулсан; / НДС 93.4 тэрбум төгрөг, ЗТС 2.7 тэрбум төгрөг, /
- Тайлант хугацаанд хэрэгжээгүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үлдэгдэл мөнгөн хөрөнгийг ТЕЗ-ийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан нийт 69.2 тэрбум төгрөг /МУШС (бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал хариуцсан) 60.0 тэрбум төгрөг, ССАЖЗС 7.0 тэрбум төгрөг, ХББОСС 1.0 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 1.2 тэрбум төгрөг/
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн нийт 9.5 тэрбум төгрөг; / СС 2.0 тэрбум төгрөг, ЗТС 1.9 тэрбум төгрөг, БС 1.6 тэрбум төгрөг, МУШС 1.1 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 2.9 тэрбум төгрөг/
- Улсын төсөвт төвлөрүүлбэл зохих түрээсийн орлого, төсвийн зарцуулаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлээгүй, үндсэн үйл ажиллагааны орлогыг нэмэлт санхүүжилтийн дансаар авч зарцуулсан 4.2 тэрбум төгрөг; /ЗГХЭГ 1.5 тэрбум төгрөг, ССАЖЗС 1.2 тэрбум төгрөг, ХББОСС 1.1 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 0.4 тэрбум төгрөг/
- Ажилчдын цалин, урамшуулал нэмэгдлийг зөрүүтэй тооцсон, сахилгын шийтгэлтэй ажилчдад үр дүнгийн урамшуулал олгосон, татвар суутгаагүй зэрэг нийт 11.9 тэрбум төгрөг; / БС 5.6 тэрбум төгрөг, ГБХНХС 1.3 тэрбум төгрөг, СС 1.3 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 3.7 тэрбум төгрөг/
- Мөнгөн хөрөнгийг санхүүгийн тайланд зөрүүтэй тайлагнасан, зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан нийт 11.1 тэрбум төгрөг; /БС 4.6 тэрбум төгрөг, МУШС 3.6 тэрбум төгрөг, МУЕС 1.9 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 1.0 тэрбум төгрөг/
- Төрийн сангийн дансанд төвлөрүүлээгүй, арилжааны банкаар гүйлгээ хийсэн 3.2 тэрбум төгрөг; / МУШС/
- Батлагдсан төсвөөс харьяа байгууллагын зардлыг санхүүжүүлсэн 151.3 тэрбум төгрөг /БС 150.3 тэрбум төгрөг, ГБХНХС 1.0 тэрбум төгрөг/

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2,788.3 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 1,354.2 тэрбум төгрөгөөр буюу 1.9 дахин өссөн байна.



Хүснэгт №8. Орон нутгийн ТЕЗ-ийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	615.2	372.3	(242.9)	0.1
Банканд байгаа бэлэн мөнгө	1,388,035.9	798,495.8	(589,540.1)	28.6
Замд яваа мөнгөн хөрөнгө	45,462.6	318,244.8	272,782.2	11.4
Хадгаламж	56.7	1,671,216.9	1,671,160.2	59.9
Дүн	1,434,170.4	2,788,329.8	1,354,159.4	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Орон нутгийн ТЕЗ-ийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 2,072.6 тэрбум төгрөг буюу 74.3 хувийг төрийн сангийн, 587.5 тэрбум төгрөг буюу 21.1 хувийг орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой үйлдвэрийн газрын, 112.9 тэрбум төгрөг буюу 4.1 хувийг төсөвт байгууллагын, 15.3 тэрбум төгрөг буюу 0.5 хувийг төсөл сангийн мөнгөн хөрөнгө эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- Монголбанкнаас тогтоосон банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаагүй Үндэсний хөрөнгө оруулалтын банканд 2.2 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгө байршуулсан /Нийслэл/;
- Батлагдсан төсвийг зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулсан 6.6 тэрбум төгрөг; /Дорнод 1.0 тэрбум төгрөг, Нийслэл 3.2 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 2.4 тэрбум төгрөг/
- Анхан шатны баримтгүй болон бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар 4.5 тэрбум төгрөгийн ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн; /Нийслэл 1.9 тэрбум төгрөг, Булган 0.6 тэрбум төгрөг, Төв 0.6 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 1.4 тэрбум төгрөг/
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон байгуулсан гэрээний заалтыг дагаж мөрдөөгүй, гэрээ байгуулаагүй зардал гаргасан 37.9 тэрбум төгрөг; /Өмнөговь 28.4 тэрбум төгрөг, Нийслэл 7.6 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 1.9 тэрбум төгрөг/
- Орон нутгийн төсөвт төвлөрүүлбэл зохих 0.8 тэрбум төгрөгийн түрээсийн орлого, мөнгөн хөрөнгийн зарцуулаагүй үлдэгдлийг тухайн шатны төсөвт буцаан төвлөрүүлээгүй; /Орхон 0.3 тэрбум төгрөг, Нийслэл 0.4 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 0.1 тэрбум төгрөг/
- Санхүүгийн тайланд 0.6 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийг зөрүүтэй тайлагнасан, зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан; /Төв 0.2 тэрбум төгрөг, Нийслэл 0.3 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 0.1 тэрбум төгрөг/
- Ажилчдын цалин, урамшуулал нэмэгдлийг зөрүүтэй тооцож олгосон 0.6 тэрбум төгрөг; /Нийслэл 0.4 тэрбум төгрөг, Өвөрхангай 0.1 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 0.1 тэрбум төгрөг/

4.2 БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл 1,842.3 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 1,423.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №9. Богино хугацаат хөрөнгө оруулалт, байгууллагаар

/сая төгрөгөөр/

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Боловсролын зээлийн сан	144.5	58.2	(86.3)	-
Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт менежмент ҮЦК ХХК	500.0	2,450.0	1,950.0	0.1
Төрийн банк ХК	418,236.5	1,344,152.2	925,915.7	73.0
Хуримтлалын сан	-	495,646.7	495,646.7	26.9
Дүн	418,881.0	1,842,307.1	1,423,426.0	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдлийн 1,344.2 тэрбум төгрөг буюу 73.0 хувийг Төрийн банк ХК, 495.6 тэрбум төгрөг буюу 26.9 хувийг Хуримтлалын сан, 2.5 тэрбум төгрөг буюу 0.1 хувийг Нийслэлийн өмчит Улаанбаатар Хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК-ийн хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.



4.3 АВЛАГА

Авлага дансны үлдэгдэл 6,811.7 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 366.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №10. Авлага дансны ангилал, байгууллагын төрлөөр

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажиллагсадтай холбогдсон авлага	3,312.4	4,136.5	824.1	0.1
Төлбөртэй үйлчилгээний авлага	496,125.8	86,903.0	(409,222.8)	1.3
Татаас, санхүүжилтийн авлага	198,317.8	197,631.8	(686.0)	2.9
Зээлийн хүүгийн авлага	233,272.1	330,408.5	97,136.4	4.9
Дансны авлага /ТӨҮГ/	1,106,546.7	1,194,216.8	87,670.1	17.5
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	325,289.7	860,111.3	534,821.6	12.6
Бусад авлага	1,548,695.8	1,976,888.7	428,192.9	29.0
Зээлийн авлага	2,533,671.6	2,161,393.0	(372,278.6)	31.7
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	1,192,814.7	1,144,409.0	(48,405.7)	
Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага	1,340,856.9	1,016,984.0	(323,872.9)	
Дүн	6,445,231.9	6,811,689.6	366,457.7	100.0
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>				
ТӨҮГ болон ОНӨҮГ	2,686,972.3	3,101,731.7	414,759.5	45.5
Төрийн сан	1,664,181.6	1,435,236.9	(228,944.7)	21.1
Төсөвт байгууллага	577,173.1	728,947.9	151,774.8	10.7
Төсөл/Сан	1,516,904.9	1,545,773.1	28,868.2	22.7
Дүн	6,445,231.9	6,811,689.6	366,457.7	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны нийт үлдэгдлээс зээлийн авлага 2,161.4 тэрбум төгрөг буюу 31.7 хувийг, бусад авлага 1,976.9 тэрбум төгрөг буюу 29.0 хувийг, дансны авлага /ТӨҮГ/ 1,194.2 тэрбум төгрөг буюу 17.5 хувийг, татвар, НДШ-ийн авлага 860.1 тэрбум төгрөг буюу 12.6 хувийг, зээлийн хүүгийн авлага 330.4 тэрбум төгрөг буюу 4.9 хувийг, татаас санхүүжилтийн авлага 197.6 тэрбум төгрөг буюу 2.9 хувийг, төлбөртэй үйлчилгээний авлага 86.9 тэрбум төгрөг буюу 1.3 хувийг, ажиллагсадтай холбогдсон авлага 4.2 тэрбум төгрөг буюу 0.1 хувийг тус тус эзэлж байна. Тайлант онд татвар, НДШ-ийн авлага 534.8 тэрбум төгрөгөөр, бусад авлага 428.2 тэрбум төгрөгөөр, зээлийн хүүгийн авлага 97.1 тэрбум төгрөгөөр, дансны авлага 87.7 тэрбум төгрөгөөр, ажиллагсадтай холбоотой авлага 0.8 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Авлагын үлдэгдэл өмнөх оноос өсөхөд Нийслэлийн Нийтийн тээвэр бодлогын газар 99.4 тэрбум төгрөг, Дархан төмөрлөгийн үйлдвэр ТӨХК 77.0 тэрбум төгрөг, Эрдэнэс Тавантолгой ХК 52.2 тэрбум төгрөг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас авах НДШ-ийн авлага 39.6 тэрбум төгрөг, Боловсролын ерөнхий газар 31.5 тэрбум төгрөг, Таван толгой төмөр зам ХХК-ийн авлага 20.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Төв төрийн сангийн авлага

Төв төрийн сангийн авлагын үлдэгдэл 1,413.8 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 241.4 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №11. Төв төрийн сангийн авлага

/сая төгрөгөөр/

Харилцагч байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Зээлийн хүүгийн авлага	90,689.4	81,875.0	(8,814.4)	5.8
Татвар, НДШ-ийн авлага	-	124,552.1	124,552.1	8.8
Бусад авлага	243,518.5	219,999.1	(23,519.4)	15.6
Зээлийн авлага	1,320,939.7	987,368.2	(333,571.5)	69.8
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	7,904.7	9,613.2	1,708.5	0.7
Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага	1,313,035.0	977,755.0	(335,280.0)	69.1
Дүн	1,655,147.6	1,413,794.4	(241,353.2)	100.0

Эх сурвалж: Төв төрийн сангийн 2024 оны санхүүгийн тайлан



Төв төрийн сангийн нийт 1,413.8 тэрбум төгрөгийн авлагын үлдэгдлээс 987.4 тэрбум төгрөг буюу 69.8 хувийг дотоод, гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага, 220.0 тэрбум төгрөг буюу 15.6 хувийг бусад авлага, 124.6 тэрбум төгрөг буюу 8.8 хувийг татвар, НДШ-ийн авлага, 81.8 тэрбум төгрөг буюу 5.8 хувийг зээлийн хүүгийн авлага тус тус эзэлж байна.

Төв төрийн сангийн авлагын бууралт нь бусад авлагыг 23.5 тэрбум төгрөгөөр, гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлагыг 335.3 тэрбум төгрөгөөр барагдуулж, зээлийн хүүгийн авлага 8.8 тэрбум төгрөгийн эргэн төлөлт хийснээс шалтгаалжээ.

Дотоод, гадаад эх үүсвэрээс олгосон, дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага 333.5 тэрбум төгрөгөөр буурахад нийт 94 зээлийн гэрээний үндсэн төлбөр, хүүгийн төлбөрт 381.1 тэрбум төгрөг төлсөн нь нөлөөлсөн байна.

Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага

Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлагын үлдэгдэл 977.7 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 335.3 тэрбум төгрөгөөр буурчээ.

Хүснэгт №12. Төв төрийн сангийн гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн авлага

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	748,506.9	376,128.8	(372,378.1)	38.5
Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд олгосон	199,947.8	230,632.3	30,684.5	23.6
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон	364,580.3	370,993.9	6,413.6	37.9
Дүн	1,313,035.0	977,755.0	(335,280.0)	100.0

Эх сурвалж: Төв төрийн сангийн 2024 оны санхүүгийн тайлан

Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлагын 376.1 тэрбум төгрөг буюу 38.5 хувийг Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт, 230.6 тэрбум төгрөг буюу 23.6 хувийг төрийн өмчит аж ахуйн нэгжид, 371.0 тэрбум төгрөг буюу 37.9 хувийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл тус тус эзэлж байна.

Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага 335.3 тэрбум төгрөгөөр буурсан нь зээлийн үндсэн төлбөрт 307.8 тэрбум төгрөгийн, хүүгийн төлбөрт 73.3 тэрбум төгрөг төлснөөс шалтгаалсан байна.

Тайлант онд 15 төслийн хүрээнд дамжуулан зээлийн гэрээний дагуу 21 дэд зээлдэгчид 461.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож, 5 төсөл, хөтөлбөрийн гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн 106.5 тэрбум төгрөг эргэн төлөгдөж дууссан байна.

Аудитын илрүүлэлт:

- **СС:** Гадаад зээлээс санхүүжсэн 1991-1994 онд гэрээ байгуулж олгосон 26 аж ахуйн нэгжүүдээс авах нийт 126.4 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдлийг шүүхийн шийдвэрээр хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн ч авлагын үлдэгдэл валютын ханшийн зөрүүнээс шалтгаалан жил бүр нэмэгдсэн, 492.4 тэрбум төгрөгийн 1991-1996 онд олгосон эзэн холбогдогч нь тодорхойгүй, нотлох баримт хангалтгүй, дампуурсан банкттай холбоотой, шүүхийн шатандаа яваа зэргээс шалтгаалан тайлант хугацаанд тооцоо нийлж баталгаажуулах боломжгүй, барагдаагүй авлагын үлдэгдэлтэй;
- **ЗТС:** гадаадын зээлийн эх үүсвэрээр нийт 148.5 тэрбум төгрөгийг эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл авсан боловч өглөгөөр хүлээн зөвшөөрч бүртгээгүй /Зам 2 төсөл 68.6 тэрбум төгрөг, Дархан-Эрдэнэт авто зам төсөл 48.1 тэрбум төгрөг, Тээврийг сэргээх төсөл 29.1 тэрбум төгрөг, Тээврийг хөгжүүлэх төсөл 5.5 тэрбум төгрөг/, Монголын төмөр зам ТӨХК нь зээлийн эргэн төлөлт хийгээгүйгээс 87.3 тэрбум төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй;
- **ЭХС:** Тайширын усан цахилгаан станц барих төслийн гадаад зээллэгийн эх үүсвэрээс дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний хүрээнд Кувейтийн сангаас 68.5 тэрбум төгрөг, Абу-Даби сангаас олгосон 44.5 тэрбум төгрөгийг тус тус бүртгэлд тусгаагүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй, эргэн төлөлт хийгдээгүй;



Төсөвт байгууллагын авлага

Төсөвт байгууллагын авлагын үлдэгдэл 728.9 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 151.8 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №13. Төсөвт байгууллагын авлага

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Орон нутаг	149,663.2	256,037.9	106,374.7	35.1
Улсын төсөв	427,509.9	472,910.0	45,400.1	64.9
Дүн	577,173.1	728,947.9	151,774.8	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсөвт байгууллагын нийт авлагын 472.9 тэрбум төгрөг буюу 64.9 хувийг улсын ТЕЗ-ийн авлага, 256.0 тэрбум төгрөг буюу 35.1 хувийг орон нутгийн ТЕЗ-ийн авлага эзэлж байна.

Төсөвт байгууллагын авлага өмнөх оноос 151.8 тэрбум төгрөгөөр буюу 26.3 хувиар өссөн нь ГБХНХС-ын ХЭДС-гаас олгосон зээл 35.1 тэрбум төгрөг, БС-ын хөрөнгө оруулалт 31.5 тэрбум төгрөг, Нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газрын авлага 99.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Улсын ТЕЗ-ийн нийт авлагын 154.1 тэрбум төгрөг буюу 32.6 хувийг ГБХНХС, 76.2 тэрбум төгрөг буюу 16.1 хувийг ХЗДХС, 58.9 тэрбум төгрөг буюу 12.5 хувийг ХХААХҮС, 50.8 тэрбум төгрөг буюу 10.7 хувийг БС, 132.9 тэрбум төгрөг буюу 28.1 хувийг бусад ТЕЗ-ийн авлага эзэлж байна.

Орон нутгийн төсөвт байгууллагын авлагын 117.6 тэрбум төгрөг буюу 45.9 хувийг Нийслэл, 29.7 тэрбум төгрөг буюу 11.6 хувийг Өмнөговь аймаг, 18.1 тэрбум төгрөг буюу 7.1 хувийг Төв аймаг, 13.5 тэрбум төгрөг буюу 5.3 хувийг Ховд, бусад орон нутгийн ТЕЗ 77.1 тэрбум төгрөг буюу 30.1 хувийг тус тус эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- Олон жилийн насжилттай, зээлийн хугацаа хэтэрсэн, найдваргүй болох эрсдэлтэй авлагын үлдэгдэл нийт 111.0 тэрбум төгрөг; /ЭМДС 76.0 тэрбум төгрөг, ЗТС 13.2 тэрбум төгрөг, НДС 6.4 тэрбум төгрөг, Ховд 6.3 тэрбум төгрөг, Төв 3.9 тэрбум төгрөг, Өмнөговь 2.5 тэрбум төгрөг, Сэлэнгэ 0.9 тэрбум төгрөг, Орхон 0.4 тэрбум төгрөг, ГБХНХС 0.4 тэрбум төгрөг, Дорнод 0.2 тэрбум төгрөг, ЭЗХС 0.2 тэрбум төгрөг, Нийслэл 0.2 тэрбум төгрөг, Баянхонгор 0.1 тэрбум төгрөг, Завхан 0.1 тэрбум төгрөг, ГХС 0.1 тэрбум төгрөг, Говь-Сүмбэр 0.1 тэрбум төгрөг/
- Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй, шүүхийн шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй, нийт 76.3 тэрбум төгрөг; /Нийслэл 37.3 тэрбум төгрөг, ЗТС 30.3 тэрбум төгрөг, ХЗДХС 3.2 тэрбум төгрөг, БОУАӨС 0.9 тэрбум төгрөг, МУШС 0.9 тэрбум төгрөг, Өмнөговь 0.8 тэрбум төгрөг, Ховд 0.6 тэрбум төгрөг, БС 0.5 тэрбум төгрөг, ГБХНХС 0.4 тэрбум төгрөг, Архангай 0.4 тэрбум төгрөг, Төв 0.3 тэрбум төгрөг, ЭМС 0.3 тэрбум төгрөг, ХХААХҮС 0.2 тэрбум төгрөг, Дорнод 0.1 тэрбум төгрөг, Булган 0.1 тэрбум төгрөг/
- Төсвийг зохистой удирдаагүйгээс тайлант онд нийт 23.2 тэрбум төгрөгийн авлага үүсгэсэн; /МУШС 13.1 тэрбум төгрөг, ХББОСС 8.8 тэрбум төгрөг, ССАЖЗС 0.6 тэрбум төгрөг, ЭМС 0.2 тэрбум төгрөг, ҮХЦД 0.2 тэрбум төгрөг, ХХААХҮС 0.2 тэрбум төгрөг, Төв 0.1 тэрбум төгрөг/
- Авлага дансанд бүртгээгүй, зөрүүтэй тайлагнасан, нийт 15.2 тэрбум төгрөг; /ЗТС 14.2 тэрбум төгрөг, Төв 0.4 тэрбум төгрөг, Дорнод 0.3 тэрбум төгрөг, Баянхонгор 0.3 тэрбум төгрөг/

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн авлага

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн авлага 3,101.7 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 414.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №14. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн авлага

/сая төгрөгөөр/



Өмчийн хэлбэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд	2,489,841.7	2,878,948.0	389,106.3	92.8
Орон нутгийн өмчит, орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд	197,130.6	222,783.7	25,653.1	7.2
Дүн	2,686,972.3	3,101,731.7	414,759.4	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын 389.1 тэрбум төгрөг буюу 92.8 хувийг төрийн өмчит, 25.7 тэрбум төгрөг 7.2 хувийг орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн авлага тус тус эзэлж байна.

Төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн авлага өмнөх оноос 389.1 тэрбум төгрөгөөр буюу 15.6 хувиар өссөн нь Эрдэнэс Тавантолгой ХК 202.7 тэрбум төгрөг, Дарханы Төмөрлөгийн үйлдвэр ХХК 72.9 тэрбум төгрөг, Тавантолгой төмөрзам ХХК 36.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнээс голлон нөлөөлсөн байна.

Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн авлага өмнөх оноос 25.6 тэрбум төгрөгөөр буюу 13.0 хувиар өссөн нь Улаанбаатар зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ 28.7 тэрбум төгрөг, Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ 3.4 тэрбум төгрөг, Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ 2.9 тэрбум төгрөг, Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ 2.9 тэрбум төгрөг, Эрдэнэт-Ус ОНӨХК 2.8 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Аудитын илрүүлэлт:

- Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг зохистой удирдаагүйгээс нийт 166.6 тэрбум төгрөгийн авлага үүсгэсэн; /АҮЭБС 166.0 тэрбум төгрөг (Эрдэнэс монгол ХХК 165.0 тэрбум төгрөг, Таван толгой төмөр зам ХХК 0.7 тэрбум төгрөг, Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХХК 0.2 тэрбум төгрөг), ЦХХХС 0.2 тэрбум (Үндэсний дата төв ТӨҮГ 0.2 тэрбум төгрөг), ЭХС 0.1 тэрбум төгрөг (Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨҮГ 0.1 тэрбум төгрөг), Нийслэл 0.1 тэрбум төгрөг (Сүхбаатар дүүргийн Багахандайт ОНӨААТҮГ 0.1 тэрбум төгрөг), БС 0.1 тэрбум төгрөг (Монгол Улсын Их сургууль 0.1 тэрбум төгрөг), Өмнөговь 0.1 тэрбум төгрөг/
- Олон жилийн насжилттай, зээлийн хугацаа хэтэрсэн, найдваргүй болох эрсдэлтэй нийт 63.1 тэрбум төгрөг; /АҮЭБС 27.1 тэрбум төгрөг (Эрдэнэс таван толгой 25.8 тэрбум төгрөг, Тавантолгой төмөр зам 0.8 тэрбум төгрөг, Монросцветмет ХХК 0.5 тэрбум төгрөг), ХББОСС 23.9 тэрбум төгрөг (Төрийн орон сууцны корпорац 23.9 тэрбум төгрөг), ХХААХҮС 11.0 тэрбум төгрөг (Хөдөө аж ахуйн корпорац 11.0 тэрбум төгрөг), Нийслэл 0.5 тэрбум төгрөг, (Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ 0.3 тэрбум төгрөг, Олон улсын худалдаа логиستيкийн төв ХК 0.2 тэрбум төгрөг) МҮЕС 0.2 тэрбум төгрөг (Эрчим хүчний зохицуулах хороо ТӨҮГ 0.2 тэрбум төгрөг), Говь-Алтай 0.2 тэрбум төгрөг, Баянхонгор 0.2 тэрбум төгрөг/
- Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлээгүй, нийт 7.8 тэрбум төгрөг; /АҮЭБС 1.9 тэрбум төгрөг (Тавантолгой төмөр зам ХХК 1.2 тэрбум төгрөг, Монросцветмет ХХК 0.6 тэрбум төгрөг, Шивээ-Овоо ХК 0.1 тэрбум төгрөг,) ЗТС 1.6 тэрбум төгрөг (МИАТ 1.6 тэрбум төгрөг), ЦХХХС 1.4 тэрбум төгрөг (Монголын цахилгаан холбоо ТӨҮГ 1.4 тэрбум төгрөг), Баян-Өлгий 1.1 тэрбум төгрөг, ХББОСС 0.4 тэрбум төгрөг (Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл ТӨҮГ 0.4 тэрбум төгрөг), ЭХС 0.4 тэрбум төгрөг (Эрчим хүчний үндэсний төв 0.4 тэрбум төгрөг), Улаанбаатар 0.3 тэрбум төгрөг (Зорчигч тээвэр нэг ОНӨААТҮГ 0.1 тэрбум төгрөг, Асгат хүнс ОНӨААТҮГ 0.1 тэрбум төгрөг), БС 0.2 тэрбум төгрөг (Монгол Улсын Их сургууль 0.2 тэрбум төгрөг), ССАЖЗС 0.1 тэрбум төгрөг (Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв ТӨҮГ 0.1 тэрбум төгрөг)
- Авлага дансны үлдэгдлийг зөрүүтэй бүртгэсэн, санхүүгийн тайланд авлагыг тусгаагүй, нийт 2.2 тэрбум төгрөг; /Булган аймаг 1.5 тэрбум төгрөг, ЭХС 0.5 тэрбум төгрөг, (Диспетчерийн үндэсний төв 0.2 тэрбум төгрөг, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨҮГ 0.3 тэрбум төгрөг) Сүхбаатар аймаг 0.1 тэрбум төгрөг, АҮЭБС 0.1 тэрбум төгрөг (Монросцветмет ХХК 0.1 тэрбум төгрөг)

**Нийгмийн даатгалын сангийн авлага**

Авлага дансны үлдэгдэл 726.7 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 46.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №15. Авлагын дансны үлдэгдэл, байгууллагын төрлөөр /сая.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.3	-	(0.3)	-
Төлбөртэй үйлчилгээний авлага	399,910.6	-	(399,910.6)	-
Татаас, санхүүжилтийн авлага	197,940.9	197,631.8	(309.1)	27.2
Зээлийн хүүгийн авлага	-	5,204.6	5,204.6	0.7
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	-	439,549.6	439,549.6	60.5
Бусад авлага	82,654.2	84,327.8	1,673.6	11.6
Дүн	680,506.0	726,713.8	46,207.8	100.0

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын 439.6 тэрбум төгрөг буюу 60.5 хувийг татвар, НДШ-ийн, 197.6 тэрбум төгрөг буюу 27.2 хувийг татаас, санхүүжилтийн авлага, 84.3 тэрбум төгрөг буюу 11.6 хувийг бусад, 5.2 тэрбум төгрөг буюу 0.7 хувийг зээлийн хүүгийн авлага тус тус эзэлж байна.

Авлага дансны үлдэгдэл 46.2 тэрбум төгрөгөөр өссөн нь шүүхийн шийдвэрийн дагуу Чингис хаан банканд байршиж байгаа дансны үлдэгдэлд 2020 оны 8-10 дугаар сард 1.8 тэрбум төгрөгийн хүүгийн авлага тооцсон, сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын урт хугацаатай үнэт цаас 300.0 тэрбум төгрөгөөр худалдан авч, 3.4 тэрбум төгрөгийн хүүгийн авлага бүртгэсэн, төлбөртэй үйлчилгээний өмнөх оны үлдэгдэл 399.9 тэрбум төгрөгийг татвар, НДШ-ийн авлагад шилжүүлэн бүртгэсэн, аж ахуйн нэгж, байгууллагаас авах НДШ-ийн авлага 39.6 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс голлон шалтгаалжээ.

Аудитын илрүүлэлт:

- НДС-ийн Капитал банкны эрх хүлээн авагчаас авах 65.7 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулах ажил удаашралтай;
- Олон жилийн насжилттай, найдваргүй болох эрсдэлтэй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас авах 6.4 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулах талаар хууль хяналтын байгууллагад хандсан боловч хангалттай үр дүнд хүрээгүй;
- Нэгээс дээш жилийн насжилттай нийт 5.1 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулаагүй; /Өмнөговь аймгийн НДС 2.6 тэрбум төгрөг, Хэнтий аймгийн НДС 0.1 тэрбум төгрөг, Дорнод аймгийн НДС нь 0.5 тэрбум төгрөг, Багахангай дүүргийн НДС 0.1 тэрбум төгрөг, Архангай аймгийн НДС 0.01 тэрбум төгрөг, Сүхбаатар аймгийн НДС 1.4 тэрбум төгрөг, Ховд аймгийн НДС нь 0.2 тэрбум төгрөг, Баянгол дүүргийн НДС 0.2 тэрбум төгрөг/

Эрүүл мэндийн даатгалын сангийн авлага

Авлага дансны үлдэгдэл 168.8 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 88.6 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №16. Авлагын үлдэгдэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Татаас, санхүүжилтийн авлага	495.8	-	(495.8)	-
Байгууллагаас авах авлага	79,731.5	168,799.0	89,067.5	100.0
Дүн	80,227.3	168,799.0	88,571.7	100.0

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэл 88.6 тэрбум төгрөгөөр өсөхөд НДС-аас ажил олгогч болон даатгуулагчийн ЭМД-ын шимтгэлийн 89.1 тэрбум төгрөгийн авлагыг шилжүүлсэн, Үндэсний хөрөнгө оруулалтын банкнаас 2.1 тэрбум төгрөгийн хүүгийн авлагыг нэмж бүртгэсэн зэрэг нь нөлөөлжээ.

Авлагын дансанд Капитал банкны эрх хүлээн авагчаас авах 76.0 тэрбум төгрөг, Хаппи веритас ХХК-ийн Интерферон альфа эмнэлгээс авах авлага 0.9 тэрбум төгрөгийн шүүхийн шийдвэртэй он дамжсан үлдэгдэл байна.



Капитал банкны эрх хүлээн авагчаас авах 136.1 тэрбум төгрөгийн авлагаас тайлант онд ЭМДС-д 13.4 тэрбум төгрөг төвлөрүүлж, 46.7 тэрбум төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч, 76.0 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

4.4 УРЬДЧИЛГАА

Урьдчилгаа дансны үлдэгдэл 5,891.6 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 753.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №17. Урьдчилгаа данс байгууллагын төрлөөр

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ТӨҮГ болон ОНӨҮГ	4,222,584.9	4,806,175.1	583,590.2	81.6
Төрийн сан	14,842.1	-	(14,842.1)	-
Төсөвт байгууллага	490,898.2	436,463.2	(54,435.0)	7.4
Төсөл/сан	409,295.5	648,921.6	239,626.1	11.0
Дүн	5,137,620.7	5,891,559.9	753,939.2	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны нийт үлдэгдлийн 81.6 хувийг төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн, 11.0 хувийг төсөл, сангуудын, 7.4 хувийг төсөвт байгууллагын урьдчилгааны дүн тус тус эзэлж байна.

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн урьдчилгаа дансны үлдэгдэлд Эрдэнэс Тавантолгой ХК 2,821.2 тэрбум төгрөг, Тавантолгой төмөр зам ХХК 1,515.0 тэрбум төгрөг, Тавантолгой ХК 36.6 тэрбум төгрөг, бусад төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээд 433.4 тэрбум төгрөгийн урьдчилгаа байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл өмнөх оноос 753.9 тэрбум төгрөгөөр өсөхөд Эрдэнэс Тавантолгой ХК нь Хуримтлалын санд 2024 оны ногдол ашиг 200.0 тэрбум төгрөг, Үнэт цаасны хадгаламжийн төв ХХК-д ногдол ашгийн 360.9 тэрбум төгрөг, тоног төхөөрөмжийн урьдчилгаанд 136.6 тэрбум төгрөг, татварт 47.4 тэрбум төгрөг, нийт 666.2 тэрбум төгрөгийг урьдчилан шилжүүлсэн, Тавантолгой төмөр зам ХХК нь Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн үйл ажиллагааны төлбөр 55.8 тэрбум төгрөг, Боловсролын зээлийн сан нь нөхцөл заасан буцалтгүй тусламж, тэтгэлэгт 40.3 тэрбум төгрөг, Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэгт 39.4 тэрбум төгрөг, Засгийн газрын нэрэмжит тэтгэлэгт 6.9 тэрбум төгрөг, Дэлхийн шилдэг их сургуульд суралцагчдад 11.9 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, урьдчилгаа дансанд тус тус бүртгэсэн нь нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Урьдчилгаа дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, гэрээний биелэлтэд хяналт тавиагүй, бараа, ажил, үйлчилгээг үзүүлээгүй урьдчилгаа төлбөрийг шийдвэрлэх арга хэмжээ аваагүй, нийт 33.1 тэрбум төгрөг; /Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр" төсөл 16.2 тэрбум төгрөг, Монгол Улсад COVID-19 Халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төсөл 6.8 тэрбум төгрөг, Ашигт малтмал, газрын тосны газар 5.3 тэрбум төгрөг, Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл 3.4 тэрбум төгрөг, Цагдаагийн ерөнхий газрын авто бааз 0.7 тэрбум төгрөг, Шивээ-Овоо 0.3 тэрбум төгрөг, Бүгд Найрамдах Турк Улс Истанбул хот дахь Ерөнхий Консулын газар 0.3 тэрбум төгрөг, Ховд аймгийн Мөст сумын сум хөгжүүлэх сан 0.1 тэрбум төгрөг/
- Он дамжсан урьдчилгааг шийдвэрлэх, арга хэмжээ аваагүй нийт 0.8 тэрбум төгрөг; /Олон улсын худалдаа логистикийн төв ХК 0.3 тэрбум төгрөг, Туул голын сав газрын захиргаа 0.5 тэрбум төгрөг/;
- Урьдчилгаа төлбөр тайлант онд ногдох зардлыг хүлээн зөвшөөрөөгүй, дансны бичилт буруу бүртгэсэн 0.4 тэрбум төгрөг; /Чингис хааны өв, соёлын хүрээлэн 0.3 тэрбум төгрөг, Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суугаа ЭСЯ 0.1 тэрбум төгрөг/



4.5 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын үлдэгдэл 4,262.4 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 610.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №18. Бараа материал данс байгууллагын төрлөөр

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Түүхий эд материал	1,322,615.9	1,321,132.7	(1,483.2)	31.0
Дуусаагүй үйлдвэрлэл	146,640.6	198,061.6	51,421.0	4.6
Бэлэн бүтээгдэхүүн	959,049.2	1,366,921.1	407,871.9	32.1
Хангамжийн материал	1,173,309.7	1,325,406.8	152,097.1	31.1
Биологийн хөрөнгө	3,743.6	5,235.8	1,492.2	0.1
Мал амьтад	46,592.1	45,680.4	(911.7)	1.1
Дүн	3,651,951.1	4,262,438.4	610,487.3	100.0
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>				
ТӨҮГ болон ОНӨҮГ	2,123,111.4	2,582,429.2	459,317.8	60.6
Төсөвт байгууллага	1,458,338.8	1,575,267.9	116,929.1	37.0
Төсөл/ сан	70,500.9	104,741.3	34,240.4	2.4
Дүн	3,651,951.1	4,262,438.4	610,487.3	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал дансны 2,582.4 тэрбум төгрөг буюу 60.6 хувийг төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээд, 1,575.3 тэрбум төгрөг буюу 37.0 хувийг төсөвт байгууллага, 104.7 тэрбум төгрөг буюу 2.4 хувийг төсөл сангийн хөрөнгө тус тус эзэлж байна.

Бараа материалын үлдэгдэл 610.5 тэрбум төгрөгөөр өсөхөд бэлэн бүтээгдэхүүн 407.9 тэрбум төгрөгөөр, хангамжийн материал 152.1 тэрбум төгрөг, дуусаагүй үйлдвэрлэл 51.4 тэрбум төгрөг, биологийн хөрөнгө 1.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн.

Бэлэн бүтээгдэхүүний өсөлтөд АҮЭБС-ын харьяа байгууллагуудын бэлэн бүтээгдэхүүн 197.8 тэрбум төгрөгөөр, хангамжийн материал 34.9 тэрбум төгрөгөөр, сэлбэг хэрэгсэл 11.1 тэрбум төгрөгөөр, Тавантолгой ХК-ийн бараа материал 185.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь голлох нөлөө үзүүлжээ.

Аудитын илрүүлэлт:

- Орчны бохирдлыг бууруулах төсөл арга хэмжээний хүрээнд 2019-2021 оны гүйцэтгэсэн аймгуудын ДЦС-д шүүлтүүр суурилуулах, лаг шатаах үйлдвэр барих, төвийн дулааны шугам сүлжээний, хийн халаагуур нийлүүлэх ажлын нийт 7.2 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээг дуусгаж шийдвэрлээгүй, дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэлтэй; /БОУАӨС/
- Бараа материалын тайланд 0.4 тэрбум төгрөгийн хөрөнгийг буруу ангилан бүртгэсэн; /БС 0.1 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 0.3 тэрбум төгрөг/

НӨӨЦИЙН БАРАА

Нөөцийн бараа дансны үлдэгдэл 262.2 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 52.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №19. Нөөцийн бараа данс байгууллагын төрлөөр

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ТӨҮГ болон ОНӨҮГ	77,018.2	121,690.9	44,672.7	46.4
Төсөвт байгууллага	132,694.2	140,269.3	7,575.1	53.5
Төсөл/сан	339.1	249.3	(89.8)	0.1
Дүн	210,051.5	262,209.5	52,158.0	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нөөцийн бараа дансны үлдэгдэл 52.2 тэрбум төгрөгөөр өсөхөд Хөдөө аж ахуйн корпорац ТӨХХК-ийн үлдэгдэл 39.0 тэрбум төгрөгөөр, Таван толгойн түлш ХХК-ийн үлдэгдэл 3.6 тэрбум төгрөгөөр, Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн үлдэгдэл 1.5 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.



4.6 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ

Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл 15,756.9 тэрбум болж, өмнөх оноос 4,292.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №20. Бусад эргэлтийн хөрөнгө данс байгууллагын төрлөөр

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ТӨҮГ болон ОНӨҮГ	1,173,123.5	2,060,342.9	887,219.4	13.1
Төсөвт байгууллага	7,027,201.0	9,358,125.6	2,330,924.6	59.4
Төрийн сан	28,452.0	10,354.1	(18,097.9)	0.1
Төсөл/сан	3,235,819.1	4,328,101.5	1,092,282.4	27.5
Дүн	11,464,595.6	15,756,924.1	4,292,328.5	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгээсэн тайлан

Төсөвт байгууллагын бусад эргэлтийн хөрөнгө 2,330.9 тэрбум төгрөгөөр өссөн нь улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гэрээний үүргийн биелэлт хангагдах хүртэл олгосон санхүүжилтийг эргэлтийн хөрөнгө дансанд хуримтлуулан бүртгэсэнтэй холбоотой байна.

Төсөл, сангийн бусад эргэлтийн хөрөнгийн 1,092.3 тэрбум төгрөгийн өсөлтөд гадаадын зээл, тусламжийн санхүүжилтээр хэрэгжсэн 46 төсөл, хөтөлбөрийн нэгжийн тоног төхөөрөмж, зам гүүр, барилга байгууламж, ТЭЗҮ, зураг төслийн зөвлөх үйлчилгээний зардлуудыг хуримтлуулж бүртгэснээс шалтгаалжээ.

Аудитын илрүүлэлт:

- ЭМС: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх онуудад бэлтгэсэн, улсын комисс хүлээж авсан 25.3 тэрбум төгрөгийн барилгад ТӨБЗГ-ын шийдвэр гаргуулаагүй, 0.8 тэрбум төгрөгийн дууссан их засвар, 2.5 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллагад шилжүүлээгүй, өмнөх онуудад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжүүлж баригдсан 2019-2022 онд ашиглалтад орсон 28.6 тэрбум төгрөгийн 22 барилга, 0.3 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийг ЭМЯ болон ашиглагч байгууллага данс бүртгэлд давхар бүртгэсэн;
- ЭЗХС: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 20.4 тэрбум төгрөгийн 47 барилга, байгууламж, автозам, замын байгууламжийн ТЭЗҮ-ийг ашиглагч байгууллагад шилжүүлээгүй, төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлагыг хангуулах ажлыг зохион байгуулаагүйгээс магадлалын дүгнэлтийн хугацаа хүчингүй болох, төсөвт өртөг нэмэгдэх эрсдэлтэй;
- БС: Гэрээнд заасан хугацаанд багтаан ашиглалтад оруулах боломжгүй нөхцөл байдал үүссэн нийт 11.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 6 төсөл арга хэмжээний барилгын ажлын гэрээг дүгнээгүй, алданги суутган тооцоогүй, улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих 0.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Хөвсгөл аймгийн Арбулаг сумын Сүмбэр баг дахь бага сургуулийн барилгын өргөтгөлийн их засварын ажлыг ТХААГ-аас модон байшингийн зураг төсөвтэйгөөр тендер зарлан, гүйцэтгэгчийг шалгаруулж, барилгын ажлыг гүйцэтгүүлсэн;
- ХХААХҮС: Хөдөө аж ахуйн корпорац ТӨХХХ хугацаа хэтэрсэн зээлийн авлагад суутган тооцож хүлээн авсан 0.1 тэрбум төгрөгийн 2 суудлын автомашиныг тус дансанд бүртгэсэн, ЖДҮХС-ийн тайланд зээлийн эргэн төлөлтөд хураан авсан борлуулах зорилготой 21.9 тэрбум төгрөгийн хөрөнгийг эргэлтэд оруулаагүй ашиглалтын нэмэлт зардал гарсан;

4.7 УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл 13,292.0 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 1,522.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №21. Урт хугацаат хөрөнгө оруулалт, байгууллагын төрлөөр

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Урт хугацаат хадгаламж	60,011.8	57,968.0	(2,043.8)	0.4
Үнэт цаас	3,270,019.7	2,659,976.4	(610,043.3)	20.0
Урт хугацаат зээл	8,439,830.7	10,574,052.2	2,134,221.5	79.6
Дүн	11,769,862.2	13,291,996.6	1,522,134.4	100.0
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>				
ТӨҮГ болон ОНӨҮГ	9,192,091.6	10,813,811.4	1,621,719.8	81.4
Төрийн сан	2,519,863.9	2,419,857.9	(100,006.0)	18.2
Төсөвт байгууллага	57,906.7	58,327.3	420.6	0.4
Дүн	11,769,862.2	13,291,996.6	1,522,134.4	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгээсэн тайлан



Урт хугацаат хадгаламжийн дансны 57.9 тэрбум төгрөгийн үлдэгдэлд Үндэсний давхар даатгал ХК-ийн арилжааны банкнуудад байршуулсан хадгаламж 99.1 хувийг, үнэт цаасны компани дахь хадгаламж 0.9 хувийг тус тус эзэлж байна. Үүнд: Төрийн банк ХК-д 18.4 тэрбум төгрөг буюу 31.8 хувь, Голомт банканд 18.5 тэрбум төгрөг буюу 31.9 хувь, Худалдаа хөгжлийн банканд 8.2 тэрбум төгрөг буюу 14.1 хувь, ХААН банканд 8.6 тэрбум төгрөг буюу 14.8 хувийг, ХАС банканд 3.2 тэрбум төгрөг буюу 5.6 хувь, Ариг банканд 0.5 тэрбум төгрөг буюу 0.9 хувь, Богд банканд 0.5 тэрбум төгрөг буюу 0.9 хувь тус тус бүртгэлтэй байна.

Урт хугацаат үнэт цаасны үлдэгдэлд Төв төрийн сангийн үнэт цаас 48.4 хувь, Төрийн банк ХК-ийн үнэт цаас 16.2 хувь, Монголын төмөр зам ТӨХК-ийн үнэт цаас 26.1 хувь, Монгол Улсын хөгжлийн банк ХХК-ийн үнэт цаас 9.3 хувийг тус тус эзэлж байна.

Урт хугацаат үнэт цаас дансны үлдэгдэл 610.0 тэрбум төгрөгөөр буурахад Төрийн банк ХК-ийн үнэт цаас 536.6 тэрбум төгрөг, Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-ийн урт хугацаат үнэт цаас Засгийн газрын олон улсын зах зээлд гаргасан Самурай бондын 30.0 сая иен буюу 158.1 тэрбум төгрөгөөр үлдэгдэл буурсан, төрийн сангийн үнэт цаас 84.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь тус тус нөлөөлжээ.

Урт хугацаат зээлийн 56.1 хувийг дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага, 43.9 хувийг урт хугацаат хөрөнгө оруулалт, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд олгосон гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага эзэлж байна.

Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага 1,841.5 тэрбум төгрөгөөр өсөхөд хувь хүмүүст олгосон зээл 1,078.0 тэрбум төгрөг, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийнх 1,140.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, хувийн хэвшлийн хуулийн этгээдэд олгосон зээл 242.1 тэрбум төгрөгөөр, Засгийн газрын байгууллага, бусад шатны төсвийнх 135.2 тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.

Урт хугацаат хөрөнгө оруулалт 300.8 тэрбум төгрөгөөр өсөхөд Нийслэлийн өмчит Улаанбаатар Хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК-ийн тайлант онд 300.0 тэрбум төгрөгийн бонд худалдан авсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- Мон-Атом ТӨХХК нь өмнөх оны аудитаар компанийн өмчид бүртгэлтэй Төв Азийн Уран ХХК-ийн хувьцааны 21.0 хувийн өмчлөлтэй холбоотой асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэж, компанийн өөрийн хөрөнгийн өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэхээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.

4.8 ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл цэвэр дүнгээр 59,573.1 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 4,051.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт №22. Үндсэн хөрөнгө дансны ангилал, байгууллагын төрлөөр

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Газар	45,966.5	46,095.3	128.8	0.1
Биет хөрөнгө	29,965,023.6	34,670,430.8	4,705,407.2	58.2
Биет бус хөрөнгө	19,086,188.1	19,600,156.1	513,968.0	32.9
Бусад хөрөнгө	6,424,198.4	5,256,466.2	(1,167,732.2)	8.8
Дүн	55,521,376.6	59,573,148.4	4,051,771.8	100.0
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>				
ТӨҮГ болон ОНӨҮГ	36,699,729.4	38,940,047.8	2,240,318.4	65.4
Төсөл/сан	18,591,734.4	20,383,023.1	1,791,288.7	34.2
Төсөвт байгууллага	229,912.8	250,077.5	20,164.7	0.4
Дүн	55,521,376.6	59,573,148.4	4,051,771.8	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан



Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэлд 34,670.4 тэрбум төгрөг буюу 58.2 хувийг биет хөрөнгө, 19,600.2 тэрбум төгрөг буюу 32.9 хувийг биет бус хөрөнгө, 5,256.4 тэрбум төгрөг буюу 8.8 хувийг бусад хөрөнгө, 46.1 тэрбум төгрөг буюу 0.1 хувийг газар тус тус эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 4,051.8 тэрбум төгрөгөөр өссөн нь барилга байгууламж, орон сууц 1,683.5 тэрбум төгрөг, дуусаагүй барилга, байгууламж 1,208.5 тэрбум төгрөг, авто тээврийн хэрэгсэл 1,056.8 тэрбум төгрөг, машин тоног төхөөрөмж 1,367.6 тэрбум төгрөг, биет бус хөрөнгө 471.7 тэрбум төгрөг, бусад биет бус хөрөнгө 562.8 тэрбум төгрөгөөр хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- Жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийгээгүй, хөрөнгийг зөрүүтэй тоолсон, баталгаажуулаагүй, өмч хамгаалах комисс байгуулаагүй, зарим хөрөнгийг тооллогод хамруулаагүй, биетээр оршин байхгүй зэрэг нийт 1,038.8 тэрбум төгрөг; /ЗТС 1,038.7 тэрбум төгрөг, ЭМС 0.1 тэрбум төгрөг/
- Эрх бүхий дээд шатны байгууллагын шийдвэргүйгээр хөрөнгө бэлтгэсэн, хөрөнгийн асуудлыг эцэслэн шийдвэрлүүлээгүй, орон нутгийн өмчийг эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр хөрөнгөнд бүртгэсэн 25.3 тэрбум төгрөг; /ЭМС/
- Хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, төсөв батлагдаагүй байх хөрөнгө худалдан авсан, үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн нийт 22.4 тэрбум төгрөг; / БОУАӨС 18.9 тэрбум төгрөг, ЭМС 2.0 тэрбум төгрөг, АҮЭБС 1.4 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 0.1 тэрбум төгрөг/
- Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоогоогүй 1.1 тэрбум төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй; /СЗХ 0.4 тэрбум төгрөг, ЭЗХС 0.4 тэрбум төгрөг, ССАЖЗС 0.1 тэрбум төгрөг, СЕХ 0.1 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 0.1 тэрбум төгрөг/
- Газар эзэмших эрхийг үнэлж, санхүүгийн тайланд тусгаагүй, газрын гэрчилгээгүй, кадастрын зураггүй, эзэмших эрхийг баталгаажуулах ажлыг зохион байгуулаагүй, кадастрын зургаас зөрүүтэй бүртгэсэн; /ЗТС/

4.9 ӨР ТӨЛБӨР

Нийт өр төлбөрийн үлдэгдэл 57,724.0 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 2,529.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №23. Нийт өр, төлбөр дансны ангилал, байгууллагын төрлөөр /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн (+), Буурсан (-)	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	12,747,684.0	13,317,636.1	569,952.1	23.1
Богино хугацаат үнэт цаас	512,800.2	10,044.5	(502,755.7)	0.1
Богино хугацаат зээлийн өглөг	3,199,247.0	3,653,406.2	454,159.2	27.4
Өглөг	5,790,559.8	6,639,710.9	849,151.1	49.9
Урьдчилж орсон орлого	3,245,077.0	3,014,474.5	(230,602.5)	22.6
Урт хугацаат өр төлбөр дүн	42,446,501.6	44,406,365.5	1,959,864.0	76.9
Урт хугацаат үнэт цаас	13,595,979.1	15,560,012.0	1,964,032.9	35.0
Урт хугацаат зээл	28,850,522.4	28,846,353.5	(4,168.9)	65.0
Дүн	55,194,185.6	57,724,001.6	2,529,816.1	100.0
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>				
ТӨҮГ болон ОНӨҮГ	21,563,801.0	22,074,740.0	510,939.0	38.2
Төрийн сан	32,204,354.8	33,784,924.3	1,580,569.5	58.5
Төсөвт байгууллага	827,720.2	1,322,467.8	494,747.6	2.3
Төсөл/сан	598,309.5	541,869.5	(56,440.0)	1.0
Дүн	55,194,185.5	57,724,001.6	2,529,816.1	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт өр төлбөрийн 58.5 хувь буюу 33,784.9 тэрбум төгрөг нь төрийн сангийн, 38.2 хувь буюу 22,074.7 тэрбум төгрөг нь төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн, 2.3 хувь буюу 1,322.5 тэрбум төгрөг нь төсөвт байгууллагын, 1.0 хувь буюу 541.9 тэрбум төгрөг нь төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийн үлдэгдэл тус тус эзэлж байна.



Засгийн газар өрийн удирдлагын хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:

- Засгийн газрын өрийн хязгаарыг өмнө нь өнөөгийн үнэ цэнээр тооцдог байсныг нэрлэсэн үнэ цэнээр тооцдог болгож, өрийн бүртгэлийг олон улсын жишигт нийцүүлсэн;
- Монгол Улсын зээлжих зэрэглэл 2016 оны дунд үеэс хойш буурч, өндөр эрсдэлтэй ангилалд ангилагдаж байсан бол 2024 онд Фитч агентлаг “В+, тогтвортой”, Стандарт энд Пүүрс агентлаг “В+, эерэг”, Мүүдис агентлаг “В2, тогтвортой” үнэлгээг тус тус олгож, зэрэглэл ахисан;
- Өрийн зохицуулалтын хүрээнд Засгийн газар Номад болон Сенчири-1 бондыг хугацаанаас өмнө буцаан худалдан авсан;
- Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Сэргээн босголт, зээлийн банк (KFW), Глобаль сантай 2024 оны 12 дугаар сарын 9-ний өдөр өр хөрвүүлэх хэлэлцээр байгуулж, KFW банканд төлөх 29.0 сая еврогийн өрийг Монгол Улсад хэрэгжих эрүүл мэндийн салбарын төсөлд буцалтгүй тусламж болгон зарцуулах боломжийг бүрдүүлсэн байна.

Засгийн газрын өрийн үлдэгдэл 2023 оны жилийн эцсийн байдлаар 30,773.5 тэрбум төгрөг, нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 44.7 хувьтай, тэнцэж байсан бол 2024 оны жилийн эцсийн байдлаар 33,399.9 тэрбум төгрөг, нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 41.8 хувьтай тэнцэж байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-д заасны дагуу Засгийн газрын өр нь зөвхөн Монгол Улсын Засгийн газар, аймаг, нийслэлийн зүгээс өрийн хэрэгслээр үүсгэсэн төлбөрийн үүрэг болон хууль, гэрээнд заасны дагуу гаргасан Засгийн газрын өрийн баталгааны дүнг хамардаг тул төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн өрийг энэ тооцоонд хамруулдаггүй байна.

Засгийн газрын 2024 оны жилийн эцсийн үлдэгдэлд гадаад өр 32,021.5 тэрбум төгрөг буюу 95.9 хувь, дотоод өр 1,200.4 тэрбум төгрөг буюу 3.6 хувь, Засгийн газрын өрийн баталгаа 178.0 тэрбум төгрөг буюу 0.5 хувийг тус тус эзэлж байна.

Төв төрийн сангийн өр төлбөр

Төв төрийн сангийн нийт өр төлбөрийн үлдэгдэл 31,274.8 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 915.0 тэрбум төгрөгөөр буурсан байна. Үүнд урт хугацаат өр төлбөр 661.9 тэрбум төгрөгөөр, богино хугацаат өр төлбөр 253.1 тэрбум төгрөгөөр тус тус буурчээ.

Хүснэгт №24. Төрийн сангийн нийт өр, төлбөр дансны ангилал, /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн (+), Буурсан (-)	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	681,776.8	428,631.4	(253,145.4)	1.4
Богино хугацаат үнэт цаас	15,575.3	-	(15,575.3)	-
Богино хугацаат зээлийн өглөг	367,274.3	387,577.2	20,302.9	1.3
Өглөг	298,927.2	41,054.2	(257,873.0)	0.1
Урт хугацаат өр төлбөр дүн	31,508,030.5	30,846,150.4	(661,880.1)	98.6
Урт хугацаат үнэт цаас	10,605,117.4	9,265,014.7	(1,340,102.7)	29.6
Урт хугацаат зээл	20,902,913.1	21,581,135.7	678,222.6	69.0
Дүн	32,189,807.3	31,274,781.8	(915,025.5)	100.0

Эх сурвалж: Төв төрийн сангийн 2024 оны санхүүгийн тайлан

Төв төрийн сангийн нийт өр төлбөрийн 30,846.2 тэрбум төгрөг буюу 98.6 хувь нь урт хугацаат өр төлбөр, 428.6 тэрбум төгрөг буюу 1.4 хувь нь богино хугацаат өр төлбөр байна.



Төв төрийн сангийн үнэт цаас, зээл 3,296.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 2,280.4 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр төлснөөр буурсан байна.

Хүснэгт №25 Гадаад, дотоод үнэт цаас, гадаад зээлийн өглөг /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Гадаад үнэт цаас	Гадаад зээл	Дотоод үнэт цаас	Дүн
Нэмэгдсэн дүн	(17,537.6)	3,014,391.3	300,000.0	3,296,853.8
Тухайн онд шинээр гаргасан бонд, авсан зээл			300,000.0	300,000.0
Зээлийн ашиглалт		2,412,331.1		2,412,331.1
Ханшийн алдагдал	(17,537.6)	602,060.2		584,522.7
Хасагдсан дүн	909,979.0	1,232,935.9	137,500.0	2,280,414.9
Үндсэн төлбөр	909,979.0	1,232,935.9	137,500.0	2,280,414.9
Хүүгийн төлбөр	559,060.3	599,389.5	7,469.1	1,165,918.9

Эх сурвалж: Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Гадаад үнэт цаас: Засгийн газрын гадаад үнэт цаасны үлдэгдэл 8,655.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 716.7 тэрбум төгрөгөөр буурсан бөгөөд Засгийн газрын нийт өрийн багцын 25.9 хувийг эзэлж байна.

Тайлант онд гадаад үнэт цаасны төлбөрийн эдийн засаг, төсөвт үзүүлэх ачааллыг жигдлэх, өрийн үйлчилгээний зардлыг бууруулах зорилгоор олон улсын зах зээлд үнэт цаасыг арилжаалаагүй байна.

Хүснэгт 26. Гадаад үнэт цаасны үлдэгдэл, зориулалт /тэрбум төгрөг/

Нэр	Эхний үлдэгдэл	Ханшийн өөрчлөлт	Хасагдсан Үндсэн төлбөр	Хуримтлагдсан хүү	Эцсийн үлдэгдэл	Зориулалт
Сенчири-3	1,193.7	3.3		6.6	1,203.6	Өрийн зохицуулалт
Сенчири-2	2,216.9	6.2		86.0	2,309.2	"Гэрэгэ, Хуралдай" бонд
Сенчири-2027	1,705.3	3.8	296.1	23.8	1,436.8	Өрийн зохицуулалт
Сенчири-2031	1,705.3	4.8		36.6	1,746.7	"Чингис, Гэрэгэ" бонд
Номад бонд	1,971.4	5.3	40.8	22.9	1,958.7	Өрийн зохицуулалт
Хуралдай бонд	579.0	(5.9)	573	(0.1)	-	Өрийн зохицуулалт
Нийт дүн	9,371.7	17.5	909.9	175.7	8,655.0	"МУХБ Евро" бонд

Эх сурвалж: Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд "Хуралдай" бондын үндсэн төлбөрт 573.0 тэрбум төгрөг, "Сенчири-1" бондын үндсэн төлбөрт 296.1 тэрбум төгрөг, "Номад" бондын үндсэн төлбөрт 40.8 тэрбум төгрөг, нийт 909.9 тэрбум төгрөгийн үндсэн төлбөрийг төлж барагдуулжээ.

Гадаад зээл: Олон улсын банк, санхүүгийн байгууллага болон түншлэгч орнуудын нийт 19 зээлдүүлэгчээс 307 төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор авсан зээлийн 21,480.2 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр, 161.4 тэрбум төгрөгийн хуримтлагдсан хүүгийн үлдэгдэлтэй байна.


Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл нь ашиглалт 2,412.3 тэрбум төгрөг, хуримтлагдсан хүү 161.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, үндсэн төлбөрийн төлөлт 1,233.0 тэрбум төгрөг, ханшийн тэгшитгэлийн зөрүү 602.0 тэрбум төгрөгөөр буурч, нийт үлдэгдэл 21,641.6 тэрбум төгрөгт болж, Засгийн газрын нийт өрийн багцын 64.8 хувийг бүрдүүлсэн байна.

Дотоод үнэт цаас: Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл 2024 оны жилийн эцсийн байдлаар 400.5 тэрбум төгрөгт хүрч, Засгийн газрын нийт өрийн багцын 1.2 хувийг эзэлж байна.



Дүрслэл №1. Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл

/тэрбум төгрөг/



Эх сурвалж: Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдлийн 303.4 тэрбум төгрөг буюу 75.8 хувийг төсвийн улирлын чанартай орлогын дутагдлыг санхүүжүүлэх зорилгоор арилжаалсан үнэт цаас, 97.1 тэрбум төгрөг буюу 24.2 хувийг Сайн хувьцаа хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор арилжаалсан үнэт цаас тус тус эзэлж байна.

НДС-ийн 2024 оны төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлд “Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын урт хугацаат /нэг жил болон түүнээс дээш/ бонд, Монгол банкны үнэт цаас худалдан авахад зарцуулах хөрөнгийн доод хэмжээг 300,000.0 сая төгрөгөөр баталсугай” гэж заасныг үндэслэн Сангийн сайдын 2024 оны “Засгийн газрын үнэт цаас хаалттай гаргах тухай” 202 дугаар тушаалын дагуу Засгийн газраас тайлант онд НДС-д 300.0 тэрбум төгрөгийн үнэт цаасыг хаалттай хэлбэрээр арилжаалсантай холбоотойгоор Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл өссөн байна.

Засгийн газрын өрийн баталгаа: Тайлант оны эхэнд Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл 29.5 тэрбум төгрөг байсан бол жилийн эцэст 178.0 тэрбум төгрөгт хүрч өссөн нь “Чойбалсангийн дулааны цахилгаан станцыг 50 МВт-аар өргөтгөх төсөл”-ийн хүрээнд БНХАУ-ын Хөгжлийн банкнаас авсан 420.0 сая юань буюу 148.5 тэрбум төгрөгийн зээлд Засгийн газраас баталгаа гаргасантай холбоотой байна.

Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-ийн БНХАУ-ын хөгжлийн банкнаас авч ашигласан зээл 379.9 сая юань буюу 178.0 тэрбум төгрөгийг 2031 онд төлж дуусах хуваарьтай бөгөөд Төв төрийн санд тайлант оны жилийн эцсийн байдлаар 49.8 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний үлдэгдэл хуримтлагдсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн өр төлбөр

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн өр төлбөрийн үлдэгдэл 22,074.7 тэрбум төгрөг болж, 510.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №27. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн өр төлбөр

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн (+), Буурсан (-)	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	11,151,069.6	11,223,604.0	72,534.4	50.8
Богино хугацаат үнэт цаас	497,224.9	10,044.4	(487,180.5)	
Богино хугацаат зээлийн өглөг	3,158,609.0	3,653,277.9	494,668.9	
Өглөг	4,727,919.5	4,925,502.5	197,583.0	
Урьдчилж орсон орлого	2,767,316.2	2,634,779.2	(132,537.0)	
Урт хугацаат өр төлбөр дүн	10,412,731.4	10,851,136.0	438,404.6	49.2
Урт хугацаат үнэт цаас	2,990,861.7	3,786,601.1	795,739.4	
Урт хугацаат зээл	7,421,869.7	7,064,534.9	(357,334.8)	
Дүн	21,563,801.0	22,074,740.0	510,939.0	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан



Урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 438.4 тэрбум төгрөгөөр, богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 72.5 тэрбум төгрөгөөр өсөхөд дараах материаллаг өөрчлөлтүүд голлон нөлөөлсөн байна. Тухайлбал:

- Төрийн банкны харилцагчдын харилцах, хадгаламжийн нийт дүн 4,285.3 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 858.5 тэрбум төгрөгөөр /Засгийн газрын хадгаламж 392.7 тэрбум төгрөг, иргэдийн хугацаат хадгаламж 349.4 тэрбум төгрөг, бусад 116.4 тэрбум төгрөг/ буюу 25.0 хувиар өр төлбөр өссөн;
- Монгол Улсын Хөгжлийн банк ХХК нь 2024 оны 3 дугаар сард олон улсын зах зээлд хаалттай үнэт цаас арилжаалж 2026 онд дуусах хугацаатай 704.8 тэрбум төгрөгийн /200 сая ам.доллар/ эх үүсвэр татсан;
- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын татварын өр төлбөр 101.8 тэрбум төгрөг, зэсийн баяжмал худалдан авагч болон дотоодын аж ахуйн нэгжүүдийн урьдчилсан төлбөр 56.0 тэрбум төгрөг, Самсунг фирма компаниас авсан зээл 68.4 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн;
- МИАТ ТӨХК В787-9 загварын хоёр дахь онгоцны түрээсийн гэрээг байгуулснаас урт хугацаат өр 114.3 тэрбум төгрөгөөр өссөн;
- Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК-ийн биржийн гэрээний урьдчилж орсон орлого 97.8 тэрбум төгрөг, тайлант оны татварын өглөг 21.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн;
- Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн харилцагчдад төлөх 117.8 тэрбум төгрөгийн ногдол ашгийн өглөгөөр нэмэгдсэн.

Аудитын илрүүлэлт:

- Өр төлбөрийн 23.1 тэрбум төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, дутуу тайлагнасан; /Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК 0.6 тэрбум төгрөг, Төрийн орон сууцны корпорац 17.0 тэрбум төгрөг, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ 2.8 тэрбум төгрөг, Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв 0.7 тэрбум төгрөг, Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК 0.6 тэрбум төгрөг, Олон улсын худалдаа логистикийн төв ХК 0.4 тэрбум төгрөг, Монголын цахилгаан холбоо ХК 0.2 тэрбум төгрөг, Ховд АЗЗА ТӨҮГ 0.4 тэрбум төгрөг, бусад 0.4 тэрбум төгрөг/
- Эрдэнэс Тавантолгой ХК нь ногдол ашгийн өглөгийн 2.8 тэрбум төгрөгийг хувьцаа эзэмшигчийн нэрээр тусгайлан бүртгээгүй, МИАТ ТӨХК нь НДШ-ийн 1.3 тэрбум төгрөгийн өглөгийг алдаатай тайлагнасан;
- Тавантолгой дулааны цахилгаан станцын төслийн нэгж татан буугдсанаас Хөгжлийн банкнаас олгосон 14.8 сая ам.долларын зээл, хүүгийн өрийг Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК-д шилжүүлсэн ч Засгийн газрын 2023 оны 132 дугаар тогтоолоор Эрдэнэс Тавантолгой ХК-д хариуцуулсан зээлийн төлбөрийг бүрэн барагдуулаагүйгээс 18.8 сая ам.доллар буюу 64.2 тэрбум төгрөгийн өрийн үлдэгдэлтэй, жил бүр 0.9 сая ам.долларын хүүгийн өр төлбөр үргэлжлэн хуримтлагдсан;
- Гэрээний үүргээ хугацаанд нь биелүүлээгүйгээс 1.1 тэрбум төгрөгийн алданги нэмэгдэж, жилийн эцэст Хөдөө аж ахуйн корпорац ТӨХХК-ийн санхүүгийн тайланд нийт 29.5 тэрбум төгрөгийн хугацаа хэтэрсэн өр төлбөрийн үлдэгдэл бүртгэгдсэн;
- Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК-ийн нийт хөрөнгийн 76.4 хувь нь өр төлбөрөөр санхүүжигдэж, урьдчилгаа орлогоос бусад өрийн хэмжээ 20.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн.
- Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК нь Турбоагрегат №1-4-ийн шинэчлэл төслийг хийх зорилгоор Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-аас авсан 70.6 сая евро буюу 260.1 тэрбум төгрөгийн урт хугацаат зээлийн эргэн төлөлт 2024 оны 06 дугаар сараас эхлэн хуваарийн дагуу эргэн төлөлт хийгээгүйгээс тайлант оны эцэст 10.1 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр, 9.7 тэрбум төгрөгийн хүүгийн төлбөр, нийт 19.8 тэрбум төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөр үүссэн;

Төсөвт байгууллагын өр төлбөр

Төсөвт байгууллагын өр төлбөрийн үлдэгдэл 1,322.5 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 494.7 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №28. Төсвийн байгууллагын нийт өр, төлбөр

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн (+), Буурсан (-)	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	647,441.6	1,252,040.7	604,599.1	94.7
Богино хугацаат зээлийн өглөг	40,638.0	128.3	(40,509.7)	
Өглөг	540,849.8	1,061,596.2	520,746.4	



Урьдчилж орсон орлого	65,953.8	190,316.2	124,362.4	
Урт хугацаат өр төлбөр дүн	180,278.6	70,427.1	(109,851.5)	5.3
Дүн	827,720.2	1,322,467.8	494,747.6	100.0
Үүнээс, ТЕЗ-ийн төрлөөр			494,747.6	
Улсын төсвийн ТЕЗ	560,084.0	1,172,848.3	612,764.3	88.7
Орон нутгийн ТЕЗ	267,636.2	149,619.5	(118,016.7)	11.3
Дүн	827,720.2	1,322,467.8	494,747.6	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсөвт байгууллагын өр төлбөрийн 1,172.8 тэрбум төгрөг буюу 88.7 хувийг улсын ТЕЗ, 149.6 тэрбум төгрөг буюу 11.3 хувийг орон нутгийн ТЕЗ-ийн өр төлбөр тус тус эзэлж байна.

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд ЭМС 254.9 тэрбум төгрөг, ХЗДХС 213.0 тэрбум төгрөг, ЗТС 151.9 тэрбум төгрөг, БС 93.1 тэрбум төгрөг, ХББОСС 84.0 тэрбум төгрөг, МУШС 67.7 тэрбум төгрөг, БОУАӨС 54.6 тэрбум төгрөг, 20 минутын хот Үндэсний хорооны дарга 50.0 тэрбум төгрөг, Сангийн сайд 33.7 тэрбум төгрөг, Нийслэл 46.7 тэрбум төгрөг, МУЕС 23.9 тэрбум төгрөг, ХХААХҮС 22.7 тэрбум төгрөг, АТГ 21.1 тэрбум төгрөг, Дархан-Уул 20.8 тэрбум төгрөг, ЭХС 18.0 тэрбум төгрөг, ГБХНХС 17.7 тэрбум төгрөг, Орхон 12.0 тэрбум төгрөг, бусад ТЕЗ-ийн 66.2 тэрбум төгрөг байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд Нийслэл 47.2 тэрбум төгрөг, ЗТС 22.5 тэрбум төгрөг, ГБХНХС 0.4 тэрбум төгрөг, ЭЗХС 0.2 тэрбум төгрөг, УЕП 0.1 тэрбум төгрөг байна.

Аудитын илрүүлэлт:

- Өр төлбөрийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, зөрүүтэй тайлагнасан, бүртгэлд тусгаагүй 6.4 тэрбум төгрөг; /ЭМС 3.2 тэрбум төгрөг, Нийслэл 1.8 тэрбум төгрөг ЭХС 0.5 тэрбум төгрөг, БС 0.4 тэрбум төгрөг, ССАЖЗС 0.2 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 0.4 тэрбум төгрөг/
- Төсвийг зохистой удирдаагүй, өр төлбөр үүсгэсэн 8.2 тэрбум төгрөг; /МУШС 7.2 тэрбум төгрөг, ЭМС 0.2 тэрбум төгрөг, БС 0.4 тэрбум төгрөг, ССАЖЗС 0.1 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 0.3 тэрбум төгрөг/
- ХББОСС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын өр төлбөр өмнөх оноос 78.6 тэрбум төгрөг буюу 10.7 хувиар нэмэгдсэн;
- Сангийн яам, ХХААХҮЯ хооронд 2013 оны 4 дүгээр сарын 11-нд байгуулсан "Бага оврын трактор, газар тариалангийн техник худалдан авах төсөл"-ийн дамжуулан зээлийн гэрээгээр олгосон зээлийг 2020 онд төгрөгт шилжүүлж, жилийн хүүг 6 хувь, төлбөрийн хугацааг 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдөр болгон өөрчилсөн ч 2024 оны эцэст 76.2 тэрбум төгрөгийн хугацаа хэтэрсэн өглөгийн үлдэгдэлтэй;
- Өрийн удирдлагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6-д "Улсын Их Хурал нь нийгмийн үр өгөөжтэй, улсын төсөвт эргэн төлөгдөх чадваргүй төсөл, арга хэмжээг зээллэгийн хөрөнгөөр эргэн төлөгдөхгүй нөхцөлтэйгөөр санхүүжүүлэх эсэхийг тухайн жилийн Төсвийн тухай хуулиар, шаардлагатай тохиолдолд тухай бүр шийдвэрлэнэ" гэж заасан боловч хэрэгжилт нь баримтаар нотлогдоогүй;
- Засгийн газрын өрийн дарамтыг бууруулах зорилгоор эдийн засгийн өгөөж өндөртэй, хувийн хэвшлийн оролцоотой хэрэгжих боломжтой төслүүдийг төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх бодлогын хэрэгжилт хангалтгүй;
- "Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн өрийг Засгийн газрын өрийн бүрэлдэхүүнд хамруулдаггүй, "улсын секторын өр"-ийн талаар эрх зүйн зохицуулалтгүй байна.

Нийгмийн даатгалын сангийн өр төлбөр

НДС-ийн нийт өр төлбөрийн үлдэгдэл 89.1 тэрбум төгрөг болж, 42.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өмнөх оноос 42.8 тэрбум төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт төлөх ЭМД-ын шимтгэлийн 8.1 тэрбум төгрөгийн өглөг, ажилгүйдлийн даатгалын сангаас даатгуулагчид олгох 14.1 тэрбум төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийн, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж, хувь хүмүүст өгөх жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн 5.9 тэрбум төгрөгийн өглөг тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.



Урьдчилж орсон орлого дансанд сайн дурын даатгуулагч, ажил олгогч, улсын төсвөөс хариуцан төлдөг малчин, туслах малчин болон 3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эхийн нийгмийн даатгалын шимтгэлийг урьдчилж төлсөн нийт 51.7 тэрбум төгрөг бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- НДС-д ажилгүйдлийн даатгалын сангийн санхүүжилт хүрэлцээгүйгээс шалтгаалан даатгуулагчид 2024 оны 11, 12 дугаар сард олгох тэтгэмжийн нийт 14.1 тэрбум төгрөгийн өглөг үүссэн;
- Олон жилийн насжилттай, эзэн холбогдогч нь тодорхойгүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуагүй нийт 0.5 тэрбум төгрөг; /Төв аймгийн НДС 0.3 тэрбум төгрөг, БХД-ийн НДС 0.2 тэрбум төгрөг/
- Өмнөговь аймгийн НДС 1.0 тэрбум төгрөгийн өглөг үүссэн, Дорнод аймгийн НДС-ийн нийт өр төлбөрийн 37.6 хувь буюу 0.6 тэрбум төгрөг нь хувь хүмүүс болон байгууллагад өгөх өглөг эзэлж байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн өр төлбөр

ЭМДС-гийн нийт өр төлбөр 316.8 тэрбум болж, өмнөх оноос 98.5 тэрбум төгрөгөөр өссөн нь татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг нэмэгдсэнтэй холбоотой байна.

Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөгийн үлдэгдэлд улсын эмнэлэгт өгөх өглөг 228.6 тэрбум төгрөг, хувийн хэвшлийн эмнэлэгт 64.8 тэрбум төгрөг, рашаан сувилалд 5.5 тэрбум төгрөг, эмийн санд 8.2 тэрбум төгрөг, өрхийн эрүүл мэндийн төвд 9.7 тэрбум төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй гарсныг тооцоо нийлж баталгаажуулжээ.

4.10 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 64,514.1 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 12,997.7 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №29. Засгийн газрын хувь оролцоо

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал	8,029,230.9	7,867,789.2	(161,441.7)	12.2
Өмч /ТӨҮГ/	18,288,022.5	18,820,573.3	532,550.8	29.2
Нэмж төлөгдсөн капитал	18,816.5	18,396.5	(420.0)	0.1
Эздийн өмчийн бусад хэсэг	9,608,439.9	10,063,086.0	454,646.1	15.6
Хуримтлагдсан үр дүн	7,962,257.5	20,063,740.8	12,101,483.3	31.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,444,269.5	7,510,105.8	65,836.3	11.6
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	149,867.0	154,699.3	4,832.3	0.2
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	(36.6)	217.6	254.2	-
Засгийн газрын хувь оролцооны дүн	51,500,867.2	64,498,608.5	12,997,741.3	100.0
Хяналтын бус хувь оролцоо	15,463.2	15,463.2	-	-
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	51,516,330.4	64,514,071.7	12,997,741.3	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 5,236.7 тэрбум төгрөгөөр, төсөвт байгууллага 4,529.0 тэрбум төгрөг, төсөл, сан 3,965.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, төрийн сан 733.6 тэрбум төгрөгөөр буурсан байна. Тухайлбал:

- Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дүн өмнөх оноос 5,236.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд Эрдэнэс монгол ХХК, Монгол Улсын Хөгжлийн банк ХХК, Эрдэнэс Тавантолгой ХК, Улаанбаатар хөрөнгө оруулалт менежмент ҮЦК ХХК, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар зэрэг ТӨҮГ-ын нийт 6,460.7 тэрбум төгрөг;
- Төсөвт байгууллагын дүн 4,529.0 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд БХБЯ-ны хөрөнгө оруулалт, их завсар /ХББОСС/, БЕГ-ын хөрөнгө оруулалт /БС/, Соёлын салбарын хөрөнгө оруулалт, их засвар /ССАЖЗС/, Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл /СС/, ЭХЯ-ны хөрөнгө оруулалт, их засвар /ЭХС/,



ЗТЯ-ны хөрөнгө оруулалт, их засвар /ЗТС/ зэрэг төсвийн байгууллагууд нийт 6,245.5 тэрбум төгрөг;

- Төсөл/сангуудын дүн 3,965.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь Ирээдүйн өв сан 859.8 тэрбум төгрөг, НДС 539.9 тэрбум төгрөг, Хуримтлалын сан 500.6 тэрбум төгрөг, Төсвийн тогтворжуулалтын сан 443.9 тэрбум төгрөг, Монголын мянганы сорилтын сан 360.0 тэрбум төгрөг, Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах, хийн хоолой байгуулах төслийн нарийвчилсан ТЭЗҮ боловсруулах төсөл 190.9 тэрбум төгрөг, Солонго 1, 2 орон сууцны хороолол барих төсөл 325.4 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Санхүүгийн байдлын болон өмчийн өөрчлөлтийн тайланд төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой 12 хуулийн этгээдийн нийт 15.5 тэрбум төгрөгийн хяналтын бус /цөөнхийн/ хувь оролцоог тусад нь толилуулжээ.

4.11 ЗАСГИЙН ГАЗРЫН БОЛОН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДЫН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитад Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, Төв төрийн сан, НДС, ЭМДС-ийн сангийн санхүүгийн тайлан, улсын болон орон нутгийн 61 ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний 6,832 төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээд, төсөл, хөтөлбөрийн нэгж санхүүгийн тайлангийн аудитад хамрагдахаас 3,486 санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж /өөрчлөлтгүй 2,783, хязгаарлалттай 659, сөрөг 25, дүгнэлт гаргахаас татгалзсан 19/, 3,332 санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэж, 14 байгууллага аудитад хамрагдаагүй байна.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 5,832.1 тэрбум төгрөгийн алдаа илэрснээс 5,820.9 тэрбум төгрөгийн 6,501 алдааг залруулж, 11.2 тэрбум төгрөгийн 212 алдааг залруулах зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 3,253.9 тэрбум төгрөгийн 13,220 зөрчил илэрснээс 13.9 тэрбум төгрөгийн зөрчилд 2,362 төлбөрийн акт, 2,170.2 тэрбум төгрөгийн зөрчилд 4,681 албан шаардлага, 999.3 тэрбум төгрөгийн зөрчилд 6,001 зөвлөмж, 60.0 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 164 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 150 албан шаардлага хүргүүлж, 10.2 тэрбум төгрөгийн 26 асуудлыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар нийт 6,634.3 тэрбум төгрөгийн 4,201 зөрчил илэрснээс 0.6 тэрбум төгрөгийн зөрчилд 127 төлбөрийн акт, 3,936.1 тэрбум төгрөгийн зөрчилд 1,198 албан шаардлага, 2,310.0 тэрбум төгрөгийн зөрчилд 2,791 зөвлөмж өгч, 386.7 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 87 албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах 75 албан шаардлага хүргүүлж, хууль хяналтын байгууллагад 0.9 тэрбум төгрөгийн 10 асуудлыг шилжүүлэхээр шийдвэрлэсэн.

Улсын болон орон нутгийн ТЕЗ-дын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын аудитаар нийт 15,719.9 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн нь өмнөх оноос 7,582.5 тэрбум төгрөгөөр буюу 93.2 хувиар өссөн байна. Үүнээс, санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил 2,941.9 тэрбум төгрөгөөр буюу 48.0 хувиар, нийцлийн аудитаар илэрсэн зөрчил 4,623.0 тэрбум төгрөгөөр буюу 229.9 хувиар тус тус өссөн байна.

Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит

Улсын төсвийн 39 ерөнхийлөн захирагч, НДС, ЭМДС-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийснээс өөрчлөлтгүй 22, хязгаарлалттай 19 /ХХХҮС, БОУАӨС, ЗТС, НДСҮЗД, ЭХС, МУШС, ГХС, ЭМС, ХББОСС, СЕХД, ГБХНХС, ССАЖЗС, БС, ЭЗХС, ЦХИХХС, ХЭҮКД, ЦАУЗБУКД, АҮЭБС, МУСХҮҮХД / дүгнэлт өгсөн байна.

Аудитад улсын ТЕЗ-дын эрхлэх асуудлын хүрээний 4,212 төсвийн захирагч, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төсөл, хөтөлбөрийн нэгж санхүүгийн тайланд хамрагдахаас 2,322 санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж /Өөрчлөлтгүй 1,987, Хязгаарлалттай 313, Сөрөг 14, Санал дүгнэлт гаргахаас татгалзсан 7/, 1,885 санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэж, 5 байгууллагыг тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй, татан буугдсан зэрэг шалтгаанаар аудитад хамруулаагүй.



Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 4,595.8 тэрбум төгрөгийн 4,319 алдаа илэрснээс 4,588.3 тэрбум төгрөгийн 4,157 алдааг залруулж, 7.5 тэрбум төгрөгийн 162 алдааг залруулах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,875.0 тэрбум төгрөгийн 8,623 зөрчил илэрснээс 10.3 тэрбум төгрөгийн зөрчилд 1,536 төлбөрийн акт тогтоож, 1,963.0 тэрбум төгрөгийн 2,848 зөрчилд албан шаардлага, 57.6 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 84 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 81 албан шаардлага хүргүүлж, 837.4 тэрбум төгрөгийн зөрчилд 4,146 зөрчилд зөвлөмж өгч, 6.7 тэрбум төгрөгийн 12 асуудлыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар нийт 5,434.1 тэрбум төгрөгийн 2,883 зөрчил илэрснээс 0.1 тэрбум төгрөгийн зөрчилд 42 төлбөрийн акт тогтоож, 3,739.7 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах, таслан зогсоох 736 албан шаардлага, 39.3 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 48 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 46 албан шаардлага хүргүүлж, 1,655.0 тэрбум төгрөгийн зөрчилд 2,059 зөрчилд зөвлөмж өгсөн.

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит

Орон нутгийн төсвийн 22 ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар өөрчлөлтгүй 12, хязгаарлалттай 9 /Баян-Өлгий, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Ховд/, сөрөг 1 /Булган/ дүгнэлтийг өгсөн.

Төрийн аудитын тухай 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалтын дагуу санхүүгийн тайлангийн аудитаар “Сөрөг” дүгнэлт авсан 1 ТЕЗ-д хариуцлага тооцуулах албан шаардлагыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн.

Аудитад орон нутгийн ТЕЗ-дын эрхлэх асуудлын хүрээний 2,620 төсвийн захирагч, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төсөл, хөтөлбөрийн нэгжийн тайлан, зардлын дансыг хамруулахаас 1,164 байгууллагад дүгнэлт гаргаж, 1,447 санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн. Тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй, татан буугдсан, Төсвийн тухай хуулийн цаглаварт хугацаанд санхүүгийн тайлан ирүүлээгүй, эрх бүхий байгууллагаас шалгаж байгаа зэрэг шалтгаанаар 9 байгууллагыг аудитад хамруулаагүй.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 1,236.3 тэрбум төгрөгийн 2,394 алдаа илэрснээс 1,232.5 тэрбум төгрөгийн 2,344 алдааг залруулж, 3.8 тэрбум төгрөгийн 50 алдааг залруулах зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 378.5 тэрбум төгрөгийн 4,597 зөрчил илэрснээс 3.7 тэрбум төгрөгийн зөрчилд 826 төлбөрийн акт тогтоож, 207.2 тэрбум төгрөгийн зөрчилд 1,835 албан шаардлага, 2.4 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 80 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 69 албан шаардлага хүргүүлж, 161.8 тэрбум төгрөгийн зөрчилд 1,853 зөвлөмж өгч, 3.5 тэрбум төгрөгийн 14 асуудлыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар нийт 1,200.1 тэрбум төгрөгийн 1,318 зөрчил илэрснээс 0.5 тэрбум төгрөгийн зөрчилд 85 төлбөрийн акт тогтоож, 196.3 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 462 албан шаардлага, 347.4 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 39 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 29 албан шаардлага хүргүүлж, 655.1 тэрбум төгрөгийн зөрчилд 732 зөвлөмж өгч, хууль хяналтын байгууллагад 0.9 тэрбум төгрөгийн 10 асуудлыг шилжүүлэхээр шийдвэрлэсэн.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайлангийн аудит

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт 196 хуулийн этгээдийн санхүүгийн тайланг аудитад хамруулснаас 122 санхүүгийн тайланд санал дүгнэлт гаргаж, 74 байгууллагын санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн. /Өөрчлөлтгүй 80, Хязгаарлалттай 39, Сөрөг дүгнэлт 2, Дүгнэлт өгөхөөс татгалзсан 1/



Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 677.2 тэрбум төгрөгийн 245 алдаа илэрснээс 676.5 тэрбум төгрөгийн 235 алдааг аудитын явцад залруулж, 0.7 тэрбум төгрөгийн 10 алдааг залруулах зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 911.5 тэрбум төгрөгийн 800 зөрчил илрүүлснээс 0.5 тэрбум төгрөгийн 121 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 685.8 тэрбум төгрөгийн 326 зөрчилд зөрчлийг арилгах, таслан зогсоох албан шаардлага, 175.9 тэрбум төгрөгийн зөрчилд 344 зөвлөмж, 43.6 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 8 албан тушаалтанд хариуцлага тооцох 8 албан шаардлага хүргүүлж, 5.7 тэрбум төгрөгийн 1 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар нийт 1,632.2 тэрбум төгрөгийн 236 зөрчил илэрснээс, 0.1 тэрбум төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт тогтоож, 362.4 тэрбум төгрөгийн 84 зөрчилд албан шаардлага, 1,235.3 тэрбум төгрөгийн зөрчилд 138 зөвлөмж, 34.4 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 10 албан тушаалтанд хариуцлага тооцох 9 албан шаардлага хүргүүлсэн.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд нийт 17,772.4 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж, 8,765.4 тэрбум төгрөгийн зардал гаргаж, 9,007.0 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Цэвэр ашиг өмнөх оноос 4,213.7 тэрбум төгрөгөөр буюу 1.9 дахин өссөн эерэг үзүүлэлттэй байгаа боловч уул уурхай, санхүүгийн салбарын 6 хуулийн этгээд¹ нийт цэвэр ашгийн 96.1 хувийг бүрдүүлсэн байна.

Цэвэр ашгийн өсөлтөд эрдэс баялгийн голлох бүтээгдэхүүн болох нүүрс, зэсийн экспорт өмнөх онуудаас өндөр байсан, Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2022, 2023 оны төрд ногдох 3,305.2 тэрбум төгрөгийн ногдол ашгийг холбогдох шийдвэрийн² дагуу орлогоор хүлээн зөвшөөрсөн зэрэг нь голлон нөлөөлжээ.

Нийт 340.8 тэрбум төгрөгийн алдагдлын 87.5 хувийг Тавантолгой түлш ХХК, Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК, Төрийн орон сууцны корпорац ТӨХХК, Шивээ овоо ХК, Монгол Улсын Их сургууль, Монгол Улсын Хөгжлийн банк ХХК эзэлж байгаа нь тус компаниудын үйл ажиллагааны зардал өссөн, зээлийн санхүүжилтийн эх үүсвэрээр үйл ажиллагаа явуулсан зэргээс голлон шалтгаалсан байна.

Аудитын илрүүлэлт:

Бодлогын хэрэгжилт хангагдаагүй, үр дүн гараагүй:

- Төрийн өмчит хуулийн этгээдүүдийн засаглалын тогтолцоог сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэх, засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх зорилтуудыг дэвшүүлсэн³ боловч хэрэгжилт хангалтгүй;
- Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн мэдээллийн нэгдсэн системийг бий болгох⁴ ажлын хүрээнд тайлант онд холбогдох систем, тоног төхөөрөмжийн худалдан авалтууд хийгдсэн;
- Төрийн өмчит хуулийн этгээдүүдийн хувьцааг 2022-2024 онд биржээр олон нийтэд нээлттэй санал болгон арилжаалах⁵ ажлын хэрэгжилт удаашралтай байна.

¹ Өөрөөр хэлбэл нийт ашгийн 48.4 хувийг Эрдэнэс таван толгой ХК, 37.4 хувийг Эрдэнэс Монгол ХХК, 6.2 хувийг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, 1.7 хувийг Эрдэнэс алт ресурс ХХК, 1.2 хувийг Хадгаламжийн даатгалын корпорац, 1.2 хувийг Төрийн банк ХК, 3.9 хувийг бусад 82 хуулийн этгээдийн дүн тус тус эзэлж байна.

² УИХ-ын 2023 оны 10 дугаар тогтоол, МУЗГ-ын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 45, 46, 47 дугаар тогтоол, Эрдэнэс Монгол ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01 дүгээр тогтоол

³ Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 4.4.10. Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно. Шинэ сэргэлтийн бодлого 6.4. Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашиг, засаглалыг сайжруулж, олон нийтийн шууд хяналтад оруулах ажлыг зохион байгуулна. Монгол Улсын 2024 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл Долоо. Засаглалын үзүүлэлтийг сайжруулна.

7.5. Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглал, үр өгөөжийг сайжруулж, олон улсын чанарын стандартыг нэвтрүүлэн, үе шаттайгаар хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлнэ.

⁴ Монгол Улсын 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний 7.2.1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн мэдээллийн нэгдсэн системийг бий болгох.

⁵ Монгол Улсын 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний 7.2.1.2. Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2024 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах. УИХ-ын 2022 оны 16 дугаар тогтоолоор батлагдсан үндсэн чиглэл, Засгийн газрын 2022 оны 244 дүгээр тогтоол болон ТӨБЗГ-ын даргын 2022 оны 336 дугаар тушаал.



Санхүүгийн тайланг иж бүрэн, үнэн зөв ангилж тайлагнахтай холбоотой

- ЭМДС-аас нийт 228 өрхийн эмнэлэг санхүүжилт авч, нөхөрлөл хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд 208 өрхийн эмнэлгийн санхүүгийн тайланг нэгтгээгүй;
- Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн зарим улсын болон орон нутгийн төсөвт, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд санхүүгийн тайлангаа аж ахуйн нэгж, төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, тайлагналын журмуудыг мөрдсөн;

Дотоод хяналт хариуцлагатай холбоотой

- Хуулийн этгээдийн зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийг хянах, нэгтгэх, үр дүнг үнэлэх, зохих шийдвэрүүдийг тухай бүр гаргаж байх зохицуулалт тодорхойгүйгээс зорилтот түвшний тайланг нэгтгэж, хяналт хэрэгжүүлээгүй, шаардлагатай дүн шинжилгээ хийгээгүй;

Засаглал, хяналтын оролцоотой холбоотой

- Эрдэнэс Монгол ХХК-ийн төрийн эзэмшлийн хувь оролцооны эрхийг Засгийн газрын тогтоолоор баталсан дүрэмд заасны дагуу ЗГХЭГ хэрэгжүүлж байгаа боловч тус компанийн хараат, охин компанийн санхүүгийн тайлангуудыг АҮЭБС, ЭХС, ХББОСС-ын санхүүгийн тайланд нэгтгэсэн;
- Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн дотоод хяналтын тогтолцоог зөвхөн хяналт шалгалт, илрүүлэлтэд бус компанийн удирдлага, бүтцийн оновчтой зохион байгуулалт, шийдвэр гаргалт, ил тод байдал, хариуцлагын тогтолцоотой уялдуулж, үр дүнтэй зохион байгуулаагүй;

Үйл ажиллагааны үндсэн чиг үүрэгт хамааралгүй, нийгмийн шинж бүхий зардал гаргасан

- Хуулийн этгээдийн үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй, нийгмийн шинж чанар бүхий төсөл хөтөлбөр, арга хэмжээнд нийт 95.0 тэрбум төгрөгийг зарцуулсан;
- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь тайлант онд нийгмийн цех, нэгжүүдэд 65.3 тэрбум төгрөгийг зарцуулж, үйлдвэрийн ашигт ажиллагааг бууруулж, алдагдлыг нэмэгдүүлсэн;

Төрийн өмч хөрөнгийг үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй зарцуулах эрсдэл үүссэн

- Хуулийн этгээдүүдийн удирдлагын хэрэгжүүлэх чиг үүрэгтэй давхацсан чиг үүрэг бүхий хяналтын менежер, бүтээмжийн менежер, бизнес хөгжил хариуцсан менежер гэх мэт удирдах албан тушаалтнуудыг 2025 оноос эхлэн шинээр томилон ажиллуулж байгаа нь төрийн өмч хөрөнгийг үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй зарцуулах эрсдэл үүссэн;

Хувьцааны хууль эрх зүйн орчны талаар

- Эрдэнэс Тавантолгой ХК-ийн энгийн хувьцаа эзэмшигч иргэдийн 108.7 тэрбум төгрөгийн ногдол ашгийг тараагаагүй, шалтгаан нөхцөлийг судалж шийдвэрлэх талаар зохих арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй;

Эрх бүхий байгууллагаас гаргасан зарим шийдвэр нь бусад хууль тогтоомжтой нийцээгүй, үр дүн, уялдаа холбоог үнэлж тооцоогүй, зохих арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлээгүй, хуулийн этгээдийн ашигт ажиллагаа, хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхүйц байна. Тухайлбал:

- УИХ-ын 2024 оны 10 дугаар тогтоолд Эрдэнэс Тавантолгой ХК-ийн эрх бүхий этгээд ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн тохиолдолд төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн орлогоос Эрдэнэс Тавантолгой ХК, Эрдэнэс Монгол ХХК, түүний нэгдлийн болон бусад төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд хооронд үүссэн өр авлагад суутган тооцохоор тогтоосон нь төсвийн нэгдсэн байх эрх зүйн орчинтой уялдаагүй;
- Засгийн газрын 2023 оны 108 дугаар тогтоолоор баталсан Эрдэнэс Монгол ХХК-ийн дүрэмд нэгдлийн нэгдсэн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг уялдуулах хүрээнд охин, хараат компани, харьяа хуулийн этгээд, төслийн нэгж хооронд эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр зээл олгох, зээл авах, зээлийн санхүүжилтийн гэрээг байгуулах, баталгаа, батлан даалт гаргаж болохоор баталснаар нэгдлийн хараат, охин компаниудад нийт 164.9 тэрбум төгрөгийн зээл олгож авлага үүссэн;
- УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор Тавантолгой түлш ХХК-ийг нийслэлийн өмчлөлд шилжүүлэхдээ хуримтлагдсан өр төлбөрийг шийдвэрлэх арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж, сайжруулсан түлшний үнийг тогтвортой байлгахад шаардагдах нэмэлт санхүүжилтийг шийдвэрлэх арга хэмжээ авахыг Засгийн газарт даалгасан боловч хэрэгжилт хангагдаагүй;
- Засгийн газрын 2021 оны 230 дугаар тогтоолоор Богдхан төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг Тавантолгой төмөр зам ХХК-д олгож, бүтээн байгуулалтын ажлыг 2021



оны 3 улиралд багтаан эхлүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд, Барилга, хот байгуулалтын сайдад даалгаснаар Бодь Интернэшнл ХХК ерөнхий гүйцэтгэгчээр шалгарч 130.9 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан боловч Засгийн газрын 2022 оны 62 дугаар хуралдааны тэмдэглэлээр тус төслийн ажлыг түр зогсоосонтой холбоотойгоор өнөөг хүртэл ажлын гүйцэтгэлийн тайлан /IPC/ баталгаажаагүй, олгосон санхүүжилтийг хэрхэн шийдвэрлэх асуудал тодорхойгүй;

- Эрдэнэс Тавантолгой ХК-аас Засгийн газрын 2022 оны 94 дүгээр тогтоолын хүрээнд газрын тос дамжуулах хоолойн байгууламж барихад 635.7 тэрбум төгрөг, Засгийн газрын 2018 оны 387 дугаар тогтоолын хүрээнд Тавантолгой түлш ХХК-д 1,355.1 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон;

Бондын өр төлбөртэй холбоотой

- Эрдэнэс Монгол ХХК, Эрдэнэс силвер ресурс ХХК-уудын 2020 онд Эрдэнэс-1 /Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийн үүргийг үнэт цаасаар төлөх зориулалтаар гаргасан/ бондыг 5 жилийн хугацаатай, жилийн 6 хувийн хүүтэйгээр гаргасан бөгөөд 2024 оны эцэст бондын өглөг 614.9 тэрбум төгрөг, хорогдуулаагүй хөнгөлөлт 235.0 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Гэвч салхитын мөнгө, алтны үндсэн ордын баруун болон төв эрлийн талбайн батлагдсан нөөцийг 2025 оны эхний хагаст олборлож дуусах төлөвлөгөөтэй байгаа ба оныг дуустал баяжуулах үйлдвэрийг хүдрээр хангах тооцоотой байгаа нь тус бондын төлбөрийг төлөхөд эрсдэл үүсэж болзошгүй байна.

Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайлангийн аудит

Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой 400 хуулийн этгээдээс 394 байгууллага аудитад хамрагдаж, тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй болон татан буугдсан 6 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийгээгүй.

Аудитад хамрагдсан 394 хуулийн этгээдээс 237 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 157 байгууллагын санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн. /Өөрчлөлтгүй 157, Хязгаарлалттай 72, Сөрөг дүгнэлт 2, Дүгнэлт өгөхөөс татгалзсан 6/

Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 415.4 тэрбум төгрөгийн 397 алдаа илэрснээс 414.9 тэрбум төгрөгийн 380 алдааг аудитын явцад залруулж, 0.5 тэрбум төгрөгийн 17 залруулаагүй алдаанд зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 118.0 тэрбум төгрөгийн 755 зөрчил илэрснээс 0.8 тэрбум төгрөгийн 100 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 64.3 тэрбум төгрөгийн 274 зөрчилд албан шаардлага, 52.8 тэрбум төгрөгийн зөрчилд 368 зөвлөмж, 0.1 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 12 албан тушаалтанд хариуцлага тооцох 11 албан шаардлага хүргүүлж, 0.1 тэрбум төгрөгийн 2 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар 40.1 тэрбум төгрөгийн 201 зөрчил илэрснээс, 0.04 тэрбум төгрөгийн 11 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 16.1 тэрбум төгрөгийн 61 зөрчилд албан шаардлага, 20.8 тэрбум төгрөгийн зөрчилд 123 зөвлөмж, 3.2 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 6 албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд нийт 1,990.2 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж, 1,596.2 тэрбум төгрөгийн зардал гаргаж, 394.0 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Тайлант оны нийт цэвэр ашгийн 87.6 хувийг Тавантолгой ХК, 1.7 хувийг Нийслэлийн орон сууцны корпорац, 1.3 хувийг Ус сувгийн удирдах газар, 1.0 хувийг Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ тус тус эзэлж байгаа бөгөөд 8.4 хувийг бусад хуулийн этгээдийн дүн эзэлж байна.

Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн ашигт ажиллагаанд Тавантолгой ХК 412.4 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан, Нийслэлийн орон сууцны корпорац ХК-ийн үндсэн үйл ажиллагааны орлого өмнөх оноос 21.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.



Тайлант оны нийт алдагдал 76.7 тэрбум төгрөгийн 11.4 хувийг Улаанбаатар хотын Орон сууц нийтийн аж ахуйн газар ОНӨААТҮГ, 8.8 хувийг Дархан орон нутгийн зам тээвэр ОНӨААТҮГ-ын алдагдал эзэлж, бусад 204 хуулийн этгээд 79.8 хувийг эзэлж байна.

Засгийн газрын гадаад зээл, тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн санхүүгийн тайлангийн аудит

Гадаад зээл, тусламжаар хэрэгжиж буй нийт 138 (Сангийн ямаар дамжин хэрэгжих 137, бусад ТЕЗ-д хамааралтай 1) төсөл, хөтөлбөрөөс 89 нэгжийн санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэж, 49 төслийн нэгжийн санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт гаргасан. /Өөрчлөлтгүй 39, Хязгаарлалттай 10/

Хүснэгт.№30 Өөрчлөлттэй дүгнэлт өгсөн төсөл хөтөлбөрийн нэгж

Хязгаарлалттай санал дүгнэлт

1	Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл	6	Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл
2	Монгол Улсад COVID-19 Халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төсөл	7	Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл
3	Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн төслийг хөгжүүлэх төсөл	8	Хилийн үр бүтээмжийг сайжруулж тогтвортой худалдааг дэмжих төсөл
4	Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр-1 төсөл	9	Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай газар тариаланг дэмжих төсөл
5	Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн нэмэлт санхүүжилтийн төсөл	10	Зудын гамшгийн хариу арга хэмжээ төсөл

Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 367.4 тэрбум төгрөгийн 86 алдаа илэрснээс 365.0 тэрбум төгрөгийн 85 алдааг аудитын явцад залруулж, 2.4 тэрбум төгрөгийн 1 алдааг залруулах зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 275.0 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 0.3 тэрбум төгрөгийн зөрчилд 8 төлбөрийн акт тогтоож, 264.7 тэрбум төгрөгийн зөрчилд 37 албан шаардлага, 10.0 тэрбум төгрөгийн зөрчилд 30 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар нийт 161.2 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 100.1 тэрбум төгрөгийн 19 зөрчилд албан шаардлага, 1.8 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 7 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлж, 59.3 тэрбум төгрөгийн зөрчилд 21 зөвлөмж өглөө.

Засгийн газрын гадаад зээл, тусламжаар хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийг Шинэ сэргэлтийн бодлогын хөгжлийн чиглэлүүдэд нийцэж буй эсэхийг ангилбал 32.8 хувь нь нийгэм, 23.4 хувь нь хот, хөдөө, 13.1 хувь нь эрчим хүч, 11.7 хувь нь ногоон хөгжил, 10.2 хувь нь боомт, 7.3 хувь нь аж үйлдвэр, 1.5 хувь нь төрийн бүтээмжид тус тус чиглэл байна.

Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх Сангийн ямаар дамжсан нийт 137 төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 2,767.0 тэрбум төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэл 2,506.5 тэрбум төгрөг буюу 90.6 хувьтай байгаа нь өмнөх оноос 4.9 хувиар өсжээ. Батлагдсан төсвийн 72.1 хувийг хөрөнгө оруулалтын зардалд, 18.3 хувийг эргэн төлөгдөх цэвэр зээлд, үлдсэн 9.6 хувийг урсгал зардалд тус тус зарцуулсан байна.

Шилжих төлөвтэй буюу он дамжсан 80 төсөл хөтөлбөрийн ажлын дундаж гүйцэтгэл 48.7 хувь, санхүүжилтийн дундаж гүйцэтгэл 39.1 хувьтай байна.

Аудитын илрүүлэлт:

- Засгийн газрын гадаад зээл, тусламжаар хэрэгжиж буй 138 төсөл, хөтөлбөрийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 642.5 тэрбум төгрөгийн алдаа, зөрчлийг илэрснээс аудитын явцад 365.1 тэрбум төгрөгийн 85 алдааг залруулж, 0.3 тэрбум төгрөгийн 8 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 264.7 тэрбум төгрөгийн зөрчилд 37 албан шаардлага хүргүүлж, 12.4 тэрбум төгрөгийн зөрчилд 31 зөвлөмж өгсөн нь ТЕЗ-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлд тавих дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна. Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй зарим төслүүдийн хэрэгжилтийн явц удаашралтай, техник, санхүүгийн болон хууль эрх зүйн эрсдэл өндөр, гэрээний хэрэгжилт хангалтгүй;
- ТЕЗ-дад тэдгээрийн эрхлэх асуудлын хүрээний гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжих төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, гүйцэтгэл, үр дүнг хариуцуулж, төслийн үр ашиг, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах талаар холбогдох хууль, журмын хэрэгжилт хангалтгүй;



- Олон улсын хөгжлийн түнш, хандивлагч орон, олон улсын байгууллагуудаас санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний эх үүсвэрийг оновчтой тодорхойлон үр ашигтай хувилбарыг сонгож, хэлэлцээрийн дүнд хязгаарлалт тогтоох талаар хууль, тогтоомжид тусгайлан заасан зохицуулалтгүй;
- Гадаадын зээл, тусламжаар санхүүжсэн Сангийн ямаар дамжсан 137 төслийн 23.9 хувийг хотын хөгжилд, 21.8 хувийг усан хангамж, эрүүл ахуй, 14.1 хувийг эрчим хүч, 9.1 хувийг эрүүл мэндийн салбарт, 8.8 хувийг зам тээвэр, 7.0 хувийг уул уурхайн салбар, үлдсэн 15.3 хувийг бусад салбарын дүн эзэлж байна. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгасан экспортын хүчин чадал, дотоодын үйлдвэрлэл, эрчим хүчний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, нийгмийн дэд бүтцийг сайжруулах бодит эдийн засгийг дэмжих чиглэлийг дэмжсэн гадаад зээлийн ашиглалт хангалтгүй;
- Газрын тос боловсруулах цогцолборыг ашиглалтад оруулснаар 1.5 сая тонн түүхий тосноос 1.3 сая тонн бүтээгдэхүүн гарган авч, дотоодын газрын тосны хэрэглээний 55 орчим хувийг бүрэн хангах, импортын хараат байдлыг бууруулах, шатахууны үнийг бие даан уян хатан зохицуулах боломж бүрдэх төслийн нийт санхүүжилтийн дүн 1,700.0 сая ам.доллар, ашиглалт 268.6 сая ам.доллар буюу 15.8 хувь, ажлын гүйцэтгэл 23.0 хувь байна. Засгийн газрын 2023 оны “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн ЕРС-04 багц ажлын санхүүжилтийн талаар авах арга хэмжээний тухай” 336 дугаар тогтоолоор нэмэлт санхүүжилтийн гэрээ байгуулах, ажлыг эрчимжүүлэх, дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулах зэрэг шийдвэрүүд гарсан боловч хэрэгжилт хангалтгүй;
- Зэс боловсруулах цогцолбор-Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ыг түшиглэн зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах металлурги-химийн үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулсан боловч баримт бичигт тусгасан хөрөнгө оруулалтын ажлын төсөвт өртөг нэмэгдэх эрсдэл үүссэн, шаардагдах санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй;
- Монгол Улсын Засгийн газрын гадаад зээл, тусламжийн удирдлагын мэдээллийн систем (odamis)-д 2024 онд Сангийн ямаар дамжуулж хэрэгжсэн 137 төсөл нь 8 төрлийн нийт 1,096 мэдээлэл оруулахаас 304 мэдээлэл буюу 27.7 хувийг байршуулаагүй байна.

Монгол Улсын Засгийн газар гадаад улс орнууд, хөгжлийн түншүүдийн эх үүсвэрээс санхүүжих нийт 24,438.1 тэрбум төгрөгийн зээл, тусламжийн эрх үүсгэн гэрээ байгуулсан боловч, 13,330.7 тэрбум төгрөгийн зээлийн эрхийг ашиглаагүйгээс 39.4 тэрбум төгрөгийг амлалтын хүүд төлсөн нь төсөвт санхүүгийн дарамт болж, зайлшгүй шаардлагатай төсөл, хөтөлбөрүүдэд зарцуулах боломжийг хязгаарлаж байна.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дугаар тогтоолоор “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгасан экспортын хүчин чадлыг нэмэгдүүлэх, дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, эрчим хүчний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, нийгмийн дэд бүтцийг сайжруулах үндсэн 4 чиглэлийн хүрээнд нийт 14 мега төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 5 төсөл нь хэрэгжиж эхэлсэн, 5 төслийн бэлтгэл ажил хангагдсан, 4 төсөлд нэмэлт судалгаа хийхээр байна.

Засгийн газрын тусгай сангуудын санхүүгийн тайлангийн аудит

Засгийн газрын 25 тусгай сангаас 21 тусгай сангийн санхүүгийн тайланд аудит хийж, тайлант онд 4 тусгай сан үйл ажиллагаа эхлээгүй тул аудитад хамрагдаагүй.

Аудитад хамрагдсан 21 тусгай сангаас 10 тусгай сангийн санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж 2 санд “Өөрчлөлтгүй”, 8 санд “Хязгаарлалттай” /Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан, Байгаль орчин, уур амьсгалын сан, Боловсролын зээлийн сан, Улсын авто замын сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан, Эрүүл мэндийг дэмжих сан / дүгнэлт өгч, 11 санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 79.6 тэрбум төгрөгийн 46 алдаа илэрснийг аудитын явцад залруулжээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 149.5 тэрбум төгрөгийн 145 зөрчил илэрснээс 0.2 тэрбум төгрөгийн зөрчилд 11 төлбөрийн акт тогтоож, 141.2 тэрбум төгрөгийн зөрчилд 69 албан шаардлага, 0.8 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 5 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 5 албан шаардлага хүргүүлж, 7.2 тэрбум төгрөгийн зөрчилд 57 зөвлөмж өгч, 0.1 тэрбум төгрөгийн 3 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн.



Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар нийт 2,229.5 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс, 2,207.4 тэрбум төгрөгийн зөрчилд 12 албан шаардлага, 22.1 тэрбум төгрөгийн зөрчилд 38 зөвлөмж өглөө.

Засгийн газрын нийт 24 сангаас 5 сан нь зээл, дэмжлэг олгох үйл ажиллагаа явуулж байгаа, 19 сан нь тусгай хуулиар зохицуулагддаг байна.

Зээл дэмжлэг олгодог тусгай сангуудын авлагыг 5 сангийн нийт хөрөнгийн дүнтэй харьцуулан үзэхэд 94.4 хувийг эзэлж байгаа бөгөөд нийт авлагын 75.1 хувь нь нэгээс дээш жилийн насжилттай байна.

Зээл, дэмжлэг олгодог Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Орон нутаг дахь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Боловсролын зээлийн сан, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан, Шинжлэх ухаан технологийн сангуудын зээлийн авлагын эргэн төлөлтөд шинжилгээ хийж үзэхэд 37.3 хувь буюу 308.9 тэрбум төгрөгийн эргэн төлөлт найдваргүй болох эрсдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Боловсролын зээлийн сан 168.0 тэрбум төгрөг, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан 107.1 тэрбум төгрөг, Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн 33.6 тэрбум төгрөг, Шинжлэх ухаан технологийн сан 0.2 тэрбум төгрөг, нийт 308.9 тэрбум төгрөгийн олон жилийн насжилттай авлагыг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй;
- Засгийн газрын тусгай сангийн зарцуулалтыг зохицуулах журам болон сонгон шалгаруулалт явуулах нарийвчилсан эрх зүйн зохицуулалт тодорхойгүй, зарцуулалтад тавих дотоод хяналт хангалтгүй;
- ТЕЗ-ийн урсгал төсөвт урьдчилан төлөвлөж, улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх боломжтой 4.3 тэрбум төгрөгийн зардлыг эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн Засгийн газрын нөөц сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн;

4.12 САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗАЛРУУЛГА

Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад дараах залруулгыг хийлээ. Үүнд:

- Монгол банканд байрших “Хувийн хэвшлийг дэмжих II төслийн эргэн төлөлт” нэртэй гадаад валютын /ам.доллар/ дансны хаалтын ханшийг зөрүүтэй тооцсоноор мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 2.8 тэрбум төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн;
- Төрийн сангийн валютын нэгдсэн дансны үлдэгдлээс 98,466.56 ам.доллар буюу 0.3 тэрбум төгрөгийн үлдэгдлийг Эрүүл мэндийн сайд, Соёл, Спорт, Аялал Жуулчлал, Залуучуудын сайд, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын тайланд тайлагнаагүй;
- Байгууллагуудын Монголбанк болон арилжааны банканд байршуулсан гадаад төлбөр тооцооны валютын дансны 4,263.1 тэрбум төгрөгийн үлдэгдлийг төгрөгийн дансны үлдэгдлээр ангилал зөрүүтэй тайлагнасан;
- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон 15 ажлын 11.4 тэрбум төгрөгийн хөрөнгө бусад хангамжийн материал дансанд бүртгэлтэй;
- Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК 42.1 тэрбум төгрөг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам 0.1 тэрбум төгрөг, Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын Засаг даргын тамгын газар 0.1 тэрбум төгрөгийн газар эзэмших эрхийг буруу ангилан бүртгэсэн;
- Эрдэнэс монгол ХХК-ийн урт хугацаат хөрөнгө оруулалтын данс, Цемент шохой ХХК-ийн данс хооронд 11.9 тэрбум төгрөгийн цэвэрлэх бичилт хийсэн;
- Тавантолгой түлш ХХК нь 460.5 тэрбум төгрөгийн нийт хөрөнгө, 1,366.3 тэрбум төгрөгийн нийт өр төлбөр, 905.8 тэрбум төгрөгийн цэвэр хөрөнгөтэй санхүүгийн тайланг гаргасан боловч уг тайланг Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгээгүй байсныг аудитын явцад нэгтгүүлсэн;
- Нийслэлийн ЗДТГ-ын санхүүгийн тайлангийн өр төлбөрийн үлдэгдэлд валютын ханшийн тэгшитгэл хийгээгүй, цэвэрлэх бичилт дутуу хийсэн зэрэг нийт 13.8 тэрбум төгрөгийн залруулга хийлгэсэн;



4.13 ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгуулахаар Монгол Улсын Ерөнхий сайдад 4, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад 1, Сангийн сайдад 5, нийт 10 зөвлөмж өгсөн, Сангийн сайдад 3, Барилга, хот байгуулалтын яам /хуучин нэрээр/ 1, нийт 4 албан шаардлага хүргүүлсэн.

Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хянаж, үнэлэхэд дунджаар 57.2 хувийн биелэлттэй байна. Тухайлбал:

- Монгол Улсын Ерөнхий сайдад өгсөн 4 зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй;
- Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад өгсөн 1 зөвлөмж хэрэгжилт хангалтгүй;
- Сангийн сайдад өгсөн 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 3 зөвлөмжийн хэрэгжилт удаашралтай байна.

4.14 ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Улсын секторын дотоод аудитын бүтэц, орон тоог 2024 оны байдлаар авч үзэхэд нийт 61 ТЕЗ-аас 54 нь дотоод аудитын нэгжтэй бөгөөд 546 албан хаагчидтай, үүнээс 314 дотоод аудитор ажиллаж байна.

Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар нь ТЕЗ-дын дотоод аудитын нэгжийг үйл ажиллагааны стандарт, арга зүйн удирдлагаар хангах ажлын хүрээнд дотоод аудитын стандарт, Шилэн дансны тухай хууль болон бусад хууль, дүрэм, журмын талаар сургалт зохион байгуулан, дотоод аудитын нэгжийн үйл ажиллагаанд чанарын үнэлгээ, санхүүгийн хяналт шалгалт, үнэлгээ хийж дүгнэлт, зөвлөмжийг тухай бүр хүргүүлэн мэргэжил, арга зүйгээр ханган ажиллах үүрэгтэй.

Тайлант онд төсөвт болон төрийн өмчийн оролцоотой нийт 13 байгууллагад хяналт шалгалт хийхээр батлагдсанаас төлөвлөгөөт 13, төлөвлөгөөт бус 1, нийт 14 байгууллагын үйл ажиллагаанд болон сэдэвчилсэн хяналт шалгалт хийсэн байна.

Дотоод аудитын нэгжүүдийн 2022, 2023 оны үйл ажиллагаанд дотоод аудитын Олон Улсын стандарт, ёс зүйн дүрэм, холбогдох журмын дагуу дотоод аудитыг гүйцэтгэсэн эсэхэд хараат бусаар хөндлөнгийн үнэлгээ хийж, ТЕГ-ын ДАХШҮГ-т 5, ГЕГ-ын ХШҮДАГ-т 4, нийт 9 зөвлөмж өгч ажилласан байна.

Улсын секторын дотоод аудитын эрх зүйн орчин нь олон улсын стандартад бүрэн нийцээгүй, тогтолцоо төлөвшөөгүй, хүний нөөц тогтворгүй, дотоод аудиторов хараат бус байдал хангагдаагүйгээс дотоод аудитын нэгжүүд зөвхөн санхүүгийн хяналт, шалгалтыг гүйцэтгэж, байгууллагын зорилгодоо үр дүнтэй хүрэхэд нь туслах, эрсдэл, хяналт, засаглалын үйл явцыг системтэй үнэлж, сайжруулах чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.



5. АУДИТЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

5.1 АУДИТЫН ДҮГНЭЛТ

1. Засгийн газрын тогтоолоор 2019-2024 онд хэрэгжээгүй төсөл, арга хэмжээний нийт 1,787.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг төсвийн ерөнхийлөн захирагчдын барьцаа хөрөнгийн дансанд байршуулах шийдвэр гаргаж, төсвийн жил дамжуулан зарцуулж байгаа нь төсөвт өртөг нэмэгдэх, төсвийн сахилга бат алдагдах сөрөг үр дагавар үүсгэж байна.
2. Эрх бүхий байгууллагуудаас төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн бие даасан байдалд нөлөөлөхүйц, хууль, эрх зүйн орчинтой уялдаагүй шийдвэр гаргаж, үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй, нийгмийн шинж чанартай төсөл, арга хэмжээг санхүүжүүлж байгаа нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хөндөгдөх, ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.
3. Монгол Улсын Засгийн газар гадаад улс орон, хөгжлийн түншүүдийн эх үүсвэрээс нийт 24,438.1 тэрбум төгрөгийн зээл, тусламж авах гэрээ байгуулснаас 13,330.7 тэрбум төгрөгийн зээлийн эрхийг ашиглаагүйгээс 39.4 тэрбум төгрөгийг амлалтын хүүд төлсөн нь төсөвт санхүүгийн дарамт болж, зайлшгүй шаардлагатай төсөл, хөтөлбөрүүдэд зарцуулах боломжийг хязгаарлаж байна.
4. Улсын болон орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 9,068.1 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илэрч өмнөх оноос 2,941.9 тэрбум төгрөгөөр буюу 48.0 хувиар өссөн нь санхүүгийн сахилга бат, хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналт, хариуцлага хангалтгүй, аудитын шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэхгүй байгаатай холбоотой байна.
5. Эрүүл мэндийн даатгалын сангийн татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөгийн үлдэгдэл өмнөх оноос 98.5 тэрбум төгрөгөөр өссөн, шимтгэлийн хуримтлагдсан авлага 89.1 тэрбум төгрөгт хүрч сангийн төсөв алдагдалд орох нөхцөл бүрдсэн, санхүүжилтийн тогтолцоог сайжруулах, үйл ажиллагааны цогц шинэчлэл хийх шаардлагатай байна.
6. Төрийн өмчит хуулийн этгээдүүдийн хувьцааг олон нийтэд нээлттэй арилжих үйл ажиллагаа удаашралтай байгаа нь компанийн олон нийтийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх, үр ашиг, засаглалыг сайжруулах боломжийг алдагдуулж байна.
7. Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх, олон улсын жишигт нийцүүлэх бодлогын хэрэгжилт хангалтгүйгээс төрийн өмч хөрөнгийн үр өгөөж нэмэгдэхгүй, дотоод хяналтын тогтолцоо, нээлттэй, ил тод засаглалын орчин бүрдэхгүй байх эрсдэлтэй байна.
8. Дотоод аудитын эрх зүйн орчин бүрдээгүй, тогтолцоо төлөвшөөгүй, хараат бус байдал хангагдаагүйгээс зөвхөн санхүүгийн хяналт, шалгалтыг гүйцэтгэж, засаглалыг сайжруулах, эрсдэлийг удирдах гол чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.
9. Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд зарим хуулийн этгээдүүдийн хэлбэрийг үнэн зөв ангилан бүртгээгүй, санхүүгийн тайланг нэгтгэлд хамруулаагүй байгаа нь төрийн өмч, хөрөнгө иж бүрэн илэрхийлэгдэхгүй байна.
10. Засгийн газрын гадаад зээлийн эх үүсвэрээр санхүүжсэн 261.5 тэрбум төгрөгийн дамжуулан зээлийг зарим төсвийн ерөнхийлөн захирагч нар бүртгэлд тусгаагүй, эргэн төлөлт хийгдээгүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй нь найдваргүй авлага үүсэх эрсдэлтэй байна.
11. Чингис хаан, Үндэсний хөрөнгө оруулалтын банканд байршиж байгаа хуулийн этгээд, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын сангийн нийт 256.9 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгө эрсдэлтэй байгаа нь сангийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж байна.



5.2 АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

УЛСЫН ИХ ХУРАЛД ТОЛИЛУУЛАХ НЬ:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн засаглал, эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэх, үйл ажиллагааны хараат бус, ил тод байдлыг хангахад чиглэсэн өөрчлөлт сайжруулалтыг тусгахыг уламжилж байна.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД-д:

1. Тухайн оны Төсвийн тухай хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын хэрэгжээгүй төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтийг төсвийн жил дамжуулан төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулах шийдвэр гаргаж байгаа асуудлыг судалж, оновчтой арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
2. Төрийн аудитын байгууллагаас аудитаар тогтоосон төлбөрийн акт, хүргүүлсэн албан шаардлага, өгсөн зөвлөмжийн биелэлтэд дүн шинжилгээ хийж, хангалтгүй хэрэгжүүлсэн төсвийн ерөнхийлөн захирагч нарт хариуцлага тооцох, төсөв, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх;
3. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглал, эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэх, үйл ажиллагааны хараат бус, ил тод байдлыг хангах талаар Улсын Их Хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх зорилт, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхой болгож, хэрэгжилтийг хангаж ажиллах;
4. Зарим төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн санхүүгийн тайланг төрийн эзэмшлийн хувь оролцоог үндэслэлгүй, үйл ажиллагааны салбар чиглэлийг харгалзуулан нэгтгэж байгаа асуудлыг холбогдох стандарт, хуульд нийцүүлэн зүй зохистой байдлаар зохион байгуулах;
5. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн хувьцааг олон нийтэд нээлттэй арилжиж, компанийн олон нийтийн хяналт, оролцоог нэмэгдүүлэн үр ашиг, засаглалыг сайжруулах;
6. Дотоод аудитын хууль, эрх зүйн орчныг бий болгож, үр өгөөж, үр нөлөөг дээшлүүлэн аудитаар илэрч буй алдаа, зөрчлийг бууруулах арга хэмжээ авах.

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД-д

1. Олон улсын хөгжлийн түнш, хандивлагч орон, олон улсын байгууллагуудаас санхүүжих төсөл, арга хэмжээний эх үүсвэрийг оновчтой тодорхойлон үр ашигтай хувилбарыг сонгож, хэлэлцээрийн дүнд хязгаарлалт тогтоох;
2. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгасан экспортын хүчин чадал, дотоодын үйлдвэрлэл, эрчим хүчний нийлүүлэлт, эдийн засгийг дэмжих чиглэлд гадаад зээлийн ашиглалтыг нэмэгдүүлэх;
3. Дэлхийн зах зээлд зэс хайлуулах, цэвэршүүлэх зардлын хэмжээ огцом буурсан, зах зээлд үнийн тогтворгүй байдал үүссэн өнөөгийн нөхцөл байдлыг харгалзан “Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах металлурги-химийн үйлдвэр”-ийн техник, эдийн засгийн үндэслэлд эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх нэмэлт тооцоолол, судалгаа хийх, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой болгох.

САНГИЙН САЙД-д:

1. Гадаад зээлийн хэлэлцээрийг улсын төсвийн шингээх чадвар, хэрэгжих хугацаа, хөрөнгийн үр ашигтай уялдуулан төлөвлөж, ашиглаагүй эх үүсвэрээс үүсэх зардлыг бууруулах, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн хуваарьт суурилсан санхүүжилтийн зохицуулалтыг сайжруулах, дотоод хяналтын тогтолцоог бэхжүүлэх;
2. Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд байгууллагуудын хэлбэрийг үнэн зөв ангилж нэгтгэх, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг нэгтгэлд бүрэн хамруулах арга хэмжээг авч ажиллах;
3. Засгийн газрын гадаад зээлийн эх үүсвэрээр санхүүжсэн дамжуулан зээлийн үлдэгдлийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчидтай тооцоо нийлж баталгаажуулах, зээлийн авлагыг барагдуулах арга хэмжээ авах.



Монгол Улс, Улаанбаатар-15160, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: +976 51-261585. Факс: +976 11-323266, 11-324853
И-мэйл: info@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn